



ЦАГДАА-100



ЦАГДАА-100 ИННОВАЦИ

МОНГОЛ ЦАГДАА

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС



Монгол Улсын Цагдаагийн байгууллагын алба хаагчдыг НҮБ-ын Энхийг дэмжих ажиллагаанд цагдаагийн чиг үүргээр оролцуулах зорилгоор НҮБ-ын Цагдаагийн албанд ажиллах эрх олгох Сонгон шалгаруулалтын багийг 2016, 2018 онд 2 удаа хүлээн авч, сонгон шалгаруулалтын арга хэмжээг зохион байгуулан энхийг дэмжих ажиллагаанд оролцох эрхээ авсан алба хаагчдыг Африкийн Бүгд Найрамдах Өмнөд Судан Улс/БНӨСУ-UNMISS/, Бүгд Найрамдах Судан Улс/БНСудУ-UNAMID/ болон тус хоёр улсын Дундын бүс/Абей-UNISFA/ дэх НҮБ-ын Энхийг дэмжих ажиллагааны Цагдаагийн албанд бие даасан цагдаагийн ажилтнаар томилуулах ажлыг амжилттай зохион байгуулсан. Улмаар тус хэлтсээс НҮБ-ын Энхийг дэмжих ажиллагаанд 160 хүний бүрэлдэхүүнтэй бие даасан Цагдаагийн багийг оролцуулах нөхцөл боломжийг судалж, удирдлагад танилцуулан, энэ чиглэлээр Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс гаргах зөвлөмжид санал хүргүүлэн, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн цагдаагийн баг оролцуулах саналыг дэмжсэн болно.



Хүрсэн үр дүн:

НҮБ-ын Энхийг дэмжих цагдаагийн ажиллагаанд алба хаагчдыг оролцуулснаар Монгол Улсын Цагдаагийн байгууллагаас даян дэлхийд энх тайвныг тогтоох ариун үйлст хувь нэмрээ оруулж, үүрэг гүйцэтгэх мэргэжлийн мэдлэг, ур чадвар нь өндрөөр үнэлэгдэж, Монгол Улсын Цагдаагийн байгууллагын нэр төрийг олон улсын түвшинд өндөрт өргөн, үүргээ амжилттай гүйцэтгэж байна.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ИНТЕРПОЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ ТОВЧОО

**ИНТЕРПОЛЫН МЭДЭЭ, МАТЕРИАЛЫГ ХҮЛЭЭН АВАХ, ДАМЖУУЛАХ, ЖУРАМ
/КОД 132/, ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛД ХОЛБОГДСОН ГАДААДЫН ИРГЭНТЭЙ
ХАРИЛЦАХ ЖУРАМ /232/-ЫН ХОЛБОГДОХ МАЯГТУУДЫГ ТУС ТУС ЦАХИМ
ХЭЛБЭРТ ОРУУЛАХ, САН БҮРДҮҮЛЭХ**

УСЛАМАНГАА

2018 оны 11 сард Арабын Нэгдсэн Эмират Улсад зохион байгуулагдсан Интерполын Ерөнхий ассамблейн 87 дугаар чуулганы үеэр “Интерполын Үндэсний төв товчооны үйл ажиллагааны чанарын 19 стандарт”-ыг шинэчлэн баталсан бөгөөд энэхүү 19 стандартын 9 дүгээр стандарт буюу:

“Үндэсний төв товчоо нь хүлээн авсан ба илгээсэн мэдээ, мэдээлэл, хүсэлтийн цахим бүртгэлээс бүрдсэн үйл ажиллагааны бүртгэл, хяналтын цахим системтэй байна. Систем нь мэдээ, мэдээлэл, хүсэлтийг ач холбогдол болон хариу өгөх хугацаагаар нь ангилах боломжтой байна” гэсэн стандартад Монгол Улсын Интерполын Үндэсний төв товчооны үйл ажиллагааг нийцүүлэхийн тулд Ажлын албаны үйл ажиллагаанд бүртгэл, хяналтын цахим системийг нэвтрүүлэх ажлыг санаачлан хэрэгжүүлж ажиллаа.

Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанд захиалга өгч, холбогдох сүлжээний програм хангамжийг 2019 оны 03 дугаар сарын 27-нд хүлээн авсан бөгөөд хүлээн авсан өдрөөс эхлэн сүлжээний програм хангамжийг Ажлын албаны өдөр тутмын үйл ажиллагаанд нэвтрүүлэн ашиглаж туршсан. 2021 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар туршилтын хугацаанд Ажлын албаны алба хаагчид <http://interpol.police.gov> холбоост байрлах бүртгэл хяналтын тусгай санд давхардсан тоогоор нийт 960 хүнд холбогдох Интерполын шугамаар гадаад орноос хүлээн авсан мэдээллийг шивж оруулсан бол ЭЦА-ны алба хаагчид нийт 215 хүнд холбогдох мэдээллийг шивж оруулсан бөгөөд туршилтын үед илэрсэн доголдолуудыг засах чиглэлээр програм хангамжид 6 удаа засвар өөрчлөлт оруулж сайжруулсан.

Мөн <http://interpol.police.gov/> холбоост Интерполын Үндэсний төв товчооны Ажлын албанаас Интерполын мэдээ, материалыг дамжуулах үйл ажиллагааг зохицуулсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны код журмуудыг хэрэгжүүлэх аргачилсан зааварчлага, Интерполын санд оруулах гэрэл зурагт тавигдах шаардлага, Интерполын бүртгэл, хяналтын цахим санг ашиглах аргачилсан зааварчлага, Интерполын шугамаар хүлээн авсан тодорхой төрлийн гэмт хэргүүдийг үйлдэхэд ашигласан онцлог арга, хэрэгслийн талаар болон мансууруулах бодисыг нуун далдлахад ашигласан арга, хэрэгслүүдийн талаарх мэдээлэл, Монгол Улсын Гадаад харилцааны яамнаас шийтгэн олгож буй дипломат үнэмлэхний загвар зэрэг гарын авлага материалуудыг алба хаагчдын албан хэрэгцээнд зориулж цахим хэлбэрээр оруулсан.

Ийнхүү Интерполын мэдээ, мэдээллийн бүртгэл, хяналтын цахим системийг санаачлан, үйл ажиллагаандаа нэвтрүүлсэнээр дотоод ажлын бүртгэл, хяналт цахимжиж, урьд өмнө нь зөвхөн архивын тавиур болон алба хаагчдын ой санамжид үлддэг байсан мэдээллүүд цахим санд хадгалагдаж, улмаар эргэлтэд орох нөхцөл бүрдсэн. Тодорхой хугацааны дараа энэхүү цахим сан нь аливаа этгээдийн “холбогдол”-ыг шалгах ажиллагаанд зайлшгүй ашиглагддаг, цагдаагийн байгууллагын мэдээллийн сангийн нэг чухал хэсэг болно гэдэгт итгэлтэй байна.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ХУУЛИЙН ХЭЛТЭС

“ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ” /КОД/-ЫГ 2009-2011 ОНД БОЛОВСРУУЛЖ, НИЙТ 9 БҮЛЭГ, 254 ЖУРАМ /КОД/-ЫГ ЦАГДААГИЙН ЕӨРНХИЙ ГАЗРЫН ТУШААЛААР БАТЛУУЛСАН. АНХНЫ 1 ДҮГЭЭР ЭМХТГЭЛИЙГ 2011 ОНД, 2 ДУГААР ЭМХТГЭЛИЙГ 2012 ОНД, 3 ДУГААР ЭМХТГЭЛИЙГ 2013 ОНД, 4 ДҮГЭЭР ЭМХТГЭЛИЙГ 2017 ОНД ТУС ТУС ХЭВЛҮҮЛСЭН.

Цагдаагийн албаны тухай хууль, Дотоодын цэргийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны Ажлын дэд хэсэгт цагдаагийн байгууллагыг төлөөлөн ажиллаж, УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар 2017 оны 2 дугаар сарын 09-ний өдөр батлуулсан.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код/-ыг 2009-2011 онд боловсруулж, нийт 9 бүлэг, 254 журам /код/-ыг Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар батлуулсан.

Анхны 1 дүгээр эмхтгэлийг 2011 онд, 2 дугаар эмхтгэлийг 2012 онд, 3 дугаар эмхтгэлийг 2013 онд, 4 дүгээр эмхтгэлийг 2017 онд тус тус хэвлүүлсэн.



Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны зохион байгуулалт, байгууллага, алба хаагчийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлж, үйл ажиллагааны стандартыг тогтооход чухал ач холбогдолтой болсон.

Алба хаагч өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Цагдаагийн албаны үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах, цагдаагийн алба хаагчийг үр бүтээлтэй, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх, эрх зүйн байдал, нийгэм, улс төрийн баталгааг хангах, хүний эрх, эрх чөлөөг дээдлэн хүндэтгэх, зөвхөн албаны чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор зайлшгүй тохиолдолд хуулиар зөвшөөрөгдсөн хүрээнд хүний эрх, эрх чөлөөнд халдах эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

У.А.П.Д.А.А.Ц.А.Г.Д.А.А.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЭЛТЭС

**“НЭГ ХОРОМ” НӨЛӨӨЛЛИЙН АЯН 2019 ОНЫ 03 ДУГААР САРД
ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ СҮҮЛИЙН 10
ЖИЛИЙН ХУГАЦААНД ТОГТМОЛ ӨССӨН ҮЗҮҮЛЭЛТТЭЙ БАЙНА**

Тус гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах, хор уршгийг таниулах, урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн оролцоо, дэмжлэгийг нэмэгдүүлэх зорилгоор “Нэг хором” аяныг 2019 оны 03 дугаар сард Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтэс нь Хэрэг бүртгэх алба, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн дэмжлэгтэй зохион байгуулсан.

Аяны үр дүнд 2019 оны 03 дугаар сард хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 768 бүртгэгдсэн нь өмнө оны мөн үеэс 168 буюу 18 хувиар буурсан байна.



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ
 ГАЗРЫН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЭЛТЭС
 “ЯАРААД ЯАХАВ ДЭЭ” НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭ
 2019, 2020 ОНЫ 07 ДУГААР САРД

УЛААНБААТАР

Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах, иргэдэд хор уршгийг таниулах, олон нийтийн ойлголт хандлагыг өөрчлөх зорилгоор “Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл” нэгдсэн арга хэмжээний хүрээнд “Яараад яахав дээ” аянг 2019, 2020 оны 07 дугаар сард улсын хэмжээнд төрийн болон төрийн бус байгууллагуудын дэмжлэгтэйгээр зохион байгуулсан.

Өнгөрсөн онд буюу буюу 2019 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс 07 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 2018 оны мөн үеэс 50.8, гэмтсэн хүн 49.7, нас барсан хүн 11.7 хувиар тус тус буурсан. Үүнээс орон нутагт үйлдэгдсэн хэрэг 63.9, гэмтсэн хүн 59.5, нас барсан хүн 21.7 хувиар тус тус буурсан байна.

Аяны хугацаанд буюу 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 08 дугаар сарын 15-ний өдөр хүртэлх хугацаанд Улаанбаатар хотоос орон нутаг руу 741.000 орчим иргэн зорчсон нь өмнөх оны мөн үеэс 349.000 нэгжээр буюу 89 хувиар, 455.000 тээврийн хэрэгсэл нэвтэрсэн нь өнгөрсөн оны мөн үеэс хөдөлгөөн 239.000 нэгжээр буюу 2,1 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Аяны хугацаанд буюу энэ оны 07 дугаар сарын 01-ны өдрөөс 08 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг өнгөрсөн оны мөн үеэс 40.6, гэмтсэн хүн 30.5 хувиар зам тээврийн осол 8.1 хувиар тус тус буурсан хэдий ч нас барсан хүний тоо 3 буюу 3.5 хувиар өссөн байна




ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЭЛТЭС
**ШИНЭ САНАЛ САНААЧИЛГА, ТЭРГҮҮН ТУРШЛАГА
БОЛСОН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ**

Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтсээс гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр улсын хэмжээнд нэгдсэн болон хэсэгчилсэн аян, арга хэмжээнүүдийг төрийн болон төрийн бус байгууллага, иргэд олон нийтийн дэмжлэгтэйгээр зохион байгуулсан.

Зарим аян, арга хэмжээний үр дүнгээс товч дурдвал: Сүүлийн 10 жилийн хугацаанд тогтмол өссөн үзүүлэлттэй байсан “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах, хор уршгийг таниулах зорилгоор “Нэг хором” аяныг зохион байгуулсаны үр дүнд дээрх гэмт хэргийг 18 хүртэлх хувиар бууруулсан.

Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх “Яараад яахав дээ” аяныг 2019, 2020 онуудад зохион байгуулснаар 2019 онд хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг өнгөрсөн оны мөн үеэс 50.8, гэмтсэн хүн 49.7, нас барсан хүн 11.7 хувиар буурсан бол 2020 онд өнгөрсөн оны мөн үеэс 40.6, гэмтсэн хүн 30.5 хувиар зам тээврийн осол 8.1 хувиар тус тус буурсан.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн журам зөрчиж “Хүний эрүүл мэндэд болгоомжгүйгээр хүндэвтэр, хүнд хохирол учруулах” гэмт хэргээс урьдчилан сэргийлэх “Аюулгүй ажиллагаа-Амьдралын баталгаа” хэсэгчилсэн арга хэмжээний үр дүнд 46.6 хувиар буурсан байна.



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЭЛТЭС ӨСВӨРИЙН СЭРГИЙЛЭГЧ ТӨСӨЛ

ЦАГДААГИЙН
 ЕРӨНХИЙ
 ГАЗРЫН
 УРЬДЧИЛАН
 СЭРГИЙЛЭХ
 ХЭЛТЭС

Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтсээс Хүүхдийг гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх, тэдний нас, сэтгэхүйд нь тохирсон аргаар зөв хүн болгон хүмүүжүүлэх, төлөвшүүлэх, эрх зүйн боловсрол олгох зорилгоор “Өсвөрийн сэргийлэгч” төслийг 2018-2020 оны хугацаанд хэрэгжүүлж, “Сэргийлэгч хүү, зөвлөгч охин”-ы хүүхэлдэйн дүрийг бүтээж Оюуны өмчийн газраас 2018.11.01-ний өдрийн А/52 тоот тушаалаар улсын бүртгэлд бүртгүүлэн 10029 дугаартай “Зохиогчийн эрхийн гэрчилгээ” гаргуулан авсан. Хүүхдийг аливаа гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хүмүүжлийн зөв хандлагад уриалах, эрх зүйн мэдлэг олгох зорилготой “Өсвөрийн сэргийлэгч” төслийн хүрээнд бага болон өсвөр насны хүүхдүүдэд чиглэсэн ухуулга нөлөөлөл, мэдээлэл, сурталчилгааны 2 жилийн хугацаанд хэрэгжүүлэх бүтээлийг Dreem box телевизтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулан “Сэргийлэгч хүү, Зөвлөгч охины санамж” 90, “Сэргийлэгч хүү, Зөвлөгч охин” шууд нэвтрүүлэг 52 дугаар, 8 цуврал нэвтрүүлэг, 20 минутын зорилтот нэвтрүүлэг 1 хамтран хийж хүүхэд багачуудад хүргэж байна.

Төслийн хүрээнд ерөнхий боловсролын сургуулиудын дунд сурагчдад эрх зүйн мэдлэг олгох, хүүхдийн хүмүүжил, төлөвшил, үе тэнгийн манлайлалыг дээшлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Өсвөрийн сэргийлэгч 2019” тэмцээнийг улсын хэмжээнд зохион байгуулсан.


Өмнө цагдаагийн байгууллагаас хүүхдэд зориулсан хууль эрх зүйн мэдлэг олгох контент хийгдэж байгаагүй, энэ төслийг хэрэгжүүлснээр хүүхдийн сонирхлыг татсан цуврал комик ном, видео контентуудыг бэлтгэн хүргэснээр хүүхдийг ахуйн осол, гэмтэл болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд үр дүн үзүүлсэн.





ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ЭРҮҮГИЙН ЦАГДААГИЙН АЛБА
**ШИНЭ САНАЛ САНААЧИЛГА, ТЭРГҮҮН ТУРШЛАГА
БОЛСОН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ**

Эрүүгийн цагдаагийн албаны мэдээлэл, шинжилгээний ажлыг боловсронгуй болгох зорилгоор Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагаас эрхлэн гаргасан “Мэдээлэл, шинжилгээний ажилд тулгуурласан хууль сахиулах үйл ажиллагаа” нэртэй сурах бичиг, гарын авлагыг орчуулан, Эрүүгийн цагдаагийн албаны үндэсний, бүс нутгийн, орон нутгийн түвшний үйл ажиллагаанд ашиглан, Эрүүгийн цагдаагийн албаны мэдээлэл, шинжилгээний ажлыг боловсронгуй болгохоор нэвтрүүлсэн.



ХҮРСЭН ҮР ДҮН:


Алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагууд гэмт хэрэгтэй тэмцэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийтийн хэв журмыг хангах чиг үүргээ амжилттай хэрэгжүүлэхийн тулд түүнтэй холбоотой бүх төрлийн мэдээ, мэдээлэл олох, цуглуулах, үнэлж дүгнэх, шалгах, түүнд шинжилгээ хийж ашиглах зэрэг цогц үйл ажиллагааг онолын үндэстэй цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд олон улсын туршлагаас судалж нэвтрүүлснээр гэмт хэрэгтэй тэмцэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийтийн хэв журмыг хангах ажлын чиглэлээр шийдвэр гаргалт илүү оновчтой болж гэмт хэрэгтэй тэмцэх ажилд ахиц гарч байна. Бүх төрлийн дүн шинжилгээнд суурилсан шинжлэх ухааны үндэстэй, практик нэвтэрч үр дүнгээ өгч байна.

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ЭРҮҮГИЙН ЦАГДААГИЙН АЛБА
ШИНЭ САНАЛ САНААЧИЛГА, ТЭРГҮҮН ТУРШЛАГА
БОЛСОН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ**

МОНГОЛ ЦАГДАА
ЭРӨНХИЙ ГАЗАР

Малайз Улсад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болж эрх ашиг нь зөрчигдсөн Монгол Улсын 14 иргэнийг Олон Улсын шилжилт хөдөлгөөний байгууллага /ИОМ/, “Хүйсийн тэгш эрх төв” зэрэг төрийн бус байгууллагатай хамтран 3, 6 дугаар саруудад үе шаттай тусгай үүргийн онгоцоор эх оронд нь буцааж ирүүлэх ажлыг зохион байгуулсан.


Улсын хэмжээнд Хүн худалдаалах гэмт хэргийн сэжигтэн, хохирогчдыг бүртгэлжүүлэх, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх Төрийн болон Төрийн бус байгууллагуудын уялдааг сайжруулах зорилго бүхий “Хүн худалдаалах гэмт хэргийн цахим сан”-г ХЗДХЯ-ны төсвөөс 13 сая төгрөг шийдүүлэн хийлгэж үйл ажиллагаандаа ашиглаж байна.



ХҮРСЭН ҮР ДҮН:

Тус санг ашиглалтад оруулснаар хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болох 1580 иргэнийг бүртгэн санг үйл ажиллагаандаа өдөр тутам ашиглаж байна.

Эрүүгийн нөлөө бүхий гэх тодотголтой сэжигтэй этгээдүүдийн үйл хөдлөлд хяналт тавих, хувийн байдал хань харилцааг судлах үйл ажиллагааг хөнгөвчлөх зорилгоор www.OCD.POLICE.gov цахим санг ашиглалтад оруулсан.



ХҮРСЭН ҮР ДҮН:

Тус санд сэжигтэй этгээдүүдийн мэдээллийг оруулснаар тогтмол баяжилт хийж тухайн этгээдийн хувийн байдал, хань харилцааг судлах ажлыг хөнгөвчилж үйл ажиллагаанд тогтвортой ашиглаж байна.

Интерполын үндэсний төв товчоонд Гадаад улсын цагдаагийн албанаас ирүүлж байгаа хүсэлт, мэдээллийг түргэн шуурхай солилцох чиглэлээр Interpol.police.gov санг үйл ажиллагаанд ашиглалтад оруулж мэдээ мэдээллийг түргэн шуурхай солилцон ажиллаж байна.



ХҮРСЭН ҮР ДҮН:

Тус санг үйл ажиллагаанд нэвтрүүлснээр интерполын шугамаар ирсэн хүсэлтүүд чанарын шаардлага хангаж, хүсэлтийн шийдвэрлэлт хариуг түргэн, шуурхай дамжуулан үйл ажиллагааг практикт нэвтрүүлсэн.


**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ЭРҮҮГИЙН ЦАГДААГИЙН АЛБА**

**ШИНЭ САНАЛ САНААЧИЛГА, ТЭРГҮҮН ТУРШЛАГА
БОЛСОН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ**



Монголын Улсын Соёлын өвийн үндэсний төвд ашиглаж байгаа “Register” программд Цагдаагийн байгууллагын чиглэл хариуцсан хэлтсээс хандах эрх авч улсын болон аймаг, орон нутгийн үзмэр, эд өлгийн зүйлсийн хөдөлгөөнийг хянаж байх саналыг гаргаж үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн.

Соёлын өвийн Үндэсний төвд бүртгэгдэж байгаа Register программ нь Улсын болон аймаг, орон нутгийн 307 байгууллагын 126,810 дэсийн 276,077 үзмэр, эд өлгийн зүйлсийг нэр, анхдагч тодорхойлолт, эвдрэл гэмтэл, хэмжээ, жин, төрөл, хадгалагдаж байгаа байгууллага, гэрэл зураг, хувийн дугаар, хэлбэр хийц, холбогдох он, цаг, төрөл зүйл гэх мэт тус бүрд нь төрөл бүрийн хайлт хийх боломжтой ба аюулгүй байдлын хүрээнд программ руу хандалт хийх болгонд түүх болон хадгалагдахаар бүтээгдсэн. Уг программын мэдээлэл нь 4 жилд 1 удаа хийгддэг улсын тооллогын дүнгийн хүрээнд шинэчлэгдэж байхаар программчлагдсан байна.




ХҮРСЭН ҮР ДҮН:

Улсын болон аймаг, орон нутгийн 307 байгууллагын 126,810 дэсийн 276,077 үзмэрийг бүртгэлжүүлэн холбогдох мэдээллийг хугацаа алдалгүй авах боломжтой болсон


ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ЭРҮҮГИЙН ЦАГДААГИЙН АЛБА
**ШИНЭ САНАЛ САНААЧИЛГА, ТЭРГҮҮН ТУРШЛАГА
БОЛСОН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ**

АНУ-ын Төрийн Департаментаас 5 сая ам доллар буюу 14 тэрбум төгрөгийн төсөвтэй 4 жилийн хугацаатай хэрэгжих “Хүүхэд хамгаалал түншлэлийн компакт гэрээ”-г Монгол Улсад хэрэгжүүлэх зорилгоор тус улсаас манай улсад суугаа элчин сайд, холбогдох албаны хүмүүсийг удирдлагын зөвшөөрлөөр албаны зөвлөлийн хурлын өрөөнд хүлээн авч 2019-2020 оны хооронд 4 удаагийн уулзалтыг хийсний үр дүнд тус хөтөлбөрийг хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх нэгжийг үйл ажиллагаанд түшиглэн хэрэгжүүлэхээр болж энэ оны 04.02-ны өдөр гэрээнд талууд гарын үсэг зурж, 10.27-ны өдөр ГХЯ-ны хурлын тэнхимд төслийн албан ёсны нээлтийн үйл ажиллагаа зохион байгуулагдаж тасгийн дарга, цагдаагийн хошууч Ж.Төмөрбат оролцон төсөл албан ёсоор хэрэгжиж эхэлсэн. Төлөвлөгөөнд ЭЦА-ны III хэлтсийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулж оффист засвар хийх, машин, багаж, техник, тоног төхөөрөмжөөр хангана гэж тусгасан.

Нээлтийн арга хэмжээний үеийн зуралнуудаас



Монгол Улсад ГХЯСАЗАА-ны дарга Л.Нингарал




АНУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Майкл Клеверли



АНУ-ын холбогдох буй тусгай үүрэгт Эсэлийн сайд John Coburn Richmond



Монгол Улсын Хууль, гүй, дотоод хэргийн сайд Х.Ниймвалар



Арга хэлбэлд оролцсон хамтарсан багийн гишүүдийн зураг

ХҮРСЭН ҮР ДҮН:

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх нэгжийн чадавхийг нэмэгдүүлж, техник технологийн дэвшлийг ашиглан ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх 2020 оны төлөвлөгөөний санхүүжилтээр нийт 44.189.490 төгрөгийн үнэ бүхий орчин үеийн тоног төхөөрөмжүүдийг худалдан авахаар холбогдох баримт, судалгааг бүрдүүлэн ЦЕГ-ын даргад танилцуулан 2020.11.23-ны өдөр ХЗДХ-ийн сайдад хүргүүлж батлуулсан.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ЭРҮҮГИЙН ЦАГДААГИЙН АЛБА
**ШИНЭ САНАЛ САНААЧИЛГА, ТЭРГҮҮН ТУРШЛАГА
БОЛСОН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ**

МОНГОЛ ЦАГДАА

Эрүүгийн цагдаагийн албаны Зохион байгуулалттай гэмт бүлэг, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсээс хууль бус мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэрэгтэй тэмцэх, тухайн хэргийн нийгмийн хор аюулыг бусдад мэдэгдэх зорилгоор “Амьдрал мөрий биш” нөлөөллийн аяныг зохион байгуулах ажлын удирдамж төлөвлөгөөг Эрүүгийн цагдаагийн албаны даргаар батлуулан 2020 оны 09 дүгээр сарын 01-ны өдрөөс 09 дүгээр сарын 21-ний өдрийн хооронд зохион явуулсан.



ХҮРСЭН ҮР ДҮН:

ЦЕГ-ын ХМТ, Прокурорын байгууллага, Сэтгэцийн эрүүл мэндийн төв, Харилцаа холбооны зохицуулах хороо, сэтгэл зүйчдийн багтай хамтран богино хэмжээний 5 нэвтрүүлэг, урлаг, соёлын олонд танигдсан дуучид, жүжигчидтэй хамтран 16 шторк, мөрийтэй тоглоомын хор хөнөөлийн талаар 15 постер бэлтгэн “Амьдрал мөрий биш” нэртэй цахим хуудсанд байршуулан цахим орчин, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэн урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж үр дүнг тооцон ажилласан.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ЭРҮҮГИЙН ЦАГДААГИЙН АЛБА
**ШИНЭ САНАЛ САНААЧИЛГА, ТЭРГҮҮН ТУРШЛАГА
БОЛСОН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ**

Ази, Номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх бүлэг (APG)-ийн шинжээчдийн багийн зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор Эрүүгийн цагдаагийн албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газарт Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/140 дугаартай тушаалаар “Санхүүгийн шинжээч- мөрдөгч”-ийн 5 орон тоог нэмж баталсан.

Дээрх тушаалын дагуу 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн Б/454 дугаартай тушаалаар “Санхүүгийн шинжээч-мөрдөгч”-өөр 5 алба хаагч томилогдон ажиллаж байна.



ХҮРСЭН ҮР ДҮН:

“Санхүүгийн шинжээч-мөрдөгч” нар нь томилогдон ажилласнаас хойш тусгай мэдлэгийн хүрээнд 38 мөрдөгчийн магадлагаа, 42 мөрдөгчийн танилцуулгыг шинжилгээнд ирүүлсэн баримтуудыг үндэслэн гаргаж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийг богино хугацаанд шийдвэрлэх, мөрдөн шалгах ажиллагааны зардлыг багасгах, тусгай мэдлэгийн хүрээнд мэргэжил, арга зүйн хүрээнд дэмжлэг үзүүлж байна.

019 онд гаргасан 9 магадлагааг эрх бүхий байгууллагаар дүгнэлт гаргахад зах зээлийн үнэлгээ нь 260,000,000.0 төгрөгийн зардал гарах бөгөөд бодитоор цалингийн 23,400,000.0 төгрөгийн зардал, бичиг хэргийн 430,000.0 төгрөгийн зардал гаргаж, хэргийн шийдвэрлэх явцыг хурдасган нийт 236,170,000.0 төгрөгийн хэмнэлт гаргасан байна.

2020 онд гаргасан 29 магадлагааг эрх бүхий байгууллагаар дүгнэлт гаргахад зах зээлийн үнэлгээ нь 536,000,000.0 төгрөгийн зардал гарах бөгөөд бодитоор цалингийн 66,000,000.0 төгрөгийн зардал, бичиг хэргийн 1,610,000.0 төгрөгийн зардал гаргаж, хэргийн шийдвэрлэх явцыг хурдасган нийт 468,390,000.0 төгрөгийн хэмнэлт гаргасан байна.

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ЭРҮҮГИЙН ЦАГДААГИЙН АЛБА**
**ШИНЭ САНАЛ САНААЧИЛГА, ТЭРГҮҮН ТУРШЛАГА
БОЛСОН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ**

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ЭРҮҮГИЙН ЦАГДААГИЙН АЛБА

Монгол Улс 2019 оны 12 дугаар сард саарал жагсаалтад орсонтой холбоотойгоор Ази, Номхон далайн бүсийн хамтарсан бүлгийн гишүүн орны үнэлгээний хуралд 25 төлөөлөгч, үнэлгээчид, манай улсаас Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Тагнуулын ерөнхий газрын дарга, бригадын генерал Д.Гэрэл, Монгол банкны тэргүүн дэд ерөнхийлөгч Г.Дөлгөөн болон Сангийн яам, Хууль зүй, Дотоод хэргийн яам, Гадаад хэргийн яам, Монгол банк, Авлигатай тэмцэх газар, Улсын ерөнхий прокурорын газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын дээд шүүх, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар зэрэг байгууллагуудын 40 гаруй төлөөлөл оролцсоноос цагдаагийн байгууллагыг төлөөлөн ЭЦА-ны Дэд бөгөөд Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газрын дарга, цагдаагийн дэд хурандаа Т.Сүхболд, Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дарга, цагдаагийн хошууч Э.Сэргэлэнбаатар нар оролцож тайланг хамгаалсан.



ХҮРСЭН ҮР ДҮН:

2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хооронд зохион байгуулагдсан (FATF)-ийн жилийн хурлаар Монгол Улсыг “саарал жагсаалт”-аас гаргасан шийдвэрийн талаар (FATF)-ийн ерөнхийлөгч Маркус Плейер хэвлэлийн бага хурал дээр мэдэгдсэн болно.

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ЭРҮҮГИЙН ЦАГДААГИЙН АЛБА
ШИНЭ САНАЛ САНААЧИЛГА, ТЭРГҮҮН ТУРШЛАГА
БОЛСОН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ**

Цагдаагийн байгууллагын Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газрын түүхт 80 жилийн ойн хүрээнд Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам, Цагдаагийн ерөнхий газар хамтран 2018 оны 10 дугаар сарын 30-ны өдөр “Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх асуудал” Олон улсын эрдэм шинжилгээний хурлыг Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор анх удаа зохион байгуулсан.



ХҮРСЭН ҮР ДҮН:

Олон улсын эрдэм шинжилгээний хуралд дотоод, гадаадын 30 гаруй эрдэмтэн, судлаач, практик байгууллагын ажилтнууд илтгэл ирүүлсэн бөгөөд хурлын үеэр 10 илтгэлийг хэлэлцүүлж, нийт ирүүлсэн илтгэлүүдийг эмхэтгэж ном болгон хэвлүүлж олны хүртээл болгож судалгааны эргэлтэд оруулсан. “Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх асуудал” олон улсын эрдэм шинжилгээний хурал нь Монгол Улсад болон олон улсын хэмжээнд мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд тулгамдсан асуудлыг нээн илрүүлэх, түүнийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох, мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагуудын болон олон улс, бүс нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, практик байгууллагууд шууд харилцаж, мэдээлэл, туршлага солилцох боломжийг бүрдүүлэх, эрдэмтэн, судлаачдын судалгааны үр дүнг нийтийн хүртээл болгох үндсэн зорилтоо амжилттай хэрэгжүүлэн “Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх асуудал” олон улсын эрдэм шинжилгээний хурлаас гаргасан зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажилласан

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ЭРҮҮГИЙН ЦАГДААГИЙН АЛБА
**ШИНЭ САНАЛ САНААЧИЛГА, ТЭРГҮҮН ТУРШЛАГА
БОЛСОН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ**



Мал хулгайлах гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах, хор уршгийг таниулах, урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийтийн оролцоо дэмжлэгийг нэмэгдүүлэх, энэ төрлийн гэмт хэрэг үйлддэг этгээдүүдэд цохилт өгөх зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/245 дугаар тушаалаар батлагдсан “Мал мах” нэгдсэн арга хэмжээг удирдамж, төлөвлөгөөний дагуу нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагууд, орон нутгийн Засаг даргын Тамгын газар, Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлүүдийн дэмжлэгтэй улсын хэмжээнд 2020 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс 45 хоногийн хугацаанд зохион байгуулсан.



ХҮРСЭН ҮР ДҮН:

Улсын хэмжээнд 2020 оны 11 дүгээр сард 1049 мал хулгайлах гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 37.7 хувиар буурсан, энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт 44.1 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 6.1 хувиар өссөн эерэг үзүүлэлттэй байна.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ЭРҮҮГИЙН ЦАГДААГИЙН АЛБА
“САР ШИНЭ -2020” НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭ

Монголын уламжлалт цагаан сарын баяр амралтын өдрүүдийг угтан гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, үйлдэгдсэн эзэн холбогдогч нь тогтоогдоогүй байгаа гэмт хэргийн илрүүлэлт, эрэн сурвалжлах ажлын үр дүнг дээшлүүлэх зорилгоор цагдаагийн байгууллагаас жил бүр зохион явуулдаг “Сар шинэ-2020 ” нэгдсэн арга хэмжээг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн а/34 дүгээр тушаалаар батлагдсан удирдамж, төлөвлөгөөний дагуу энэ оны 02-р сарын 03-наас 28-ны өдрүүдэд улсын хэмжээнд амжилттай зохион явуулсан.



ХҮРСЭН ҮР ДҮН:

Арга хэмжээний үр дүнд энэ оны 02 дугаар сард улсын хэмжээнд 6745 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 691 буюу 9,3 хувиар буурсан, Үүнээс эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дэх хэсэгт заасан хулгайлах гэмт хэрэг өнгөрсөн оны мөн үеэс 135 буюу 6,8 хувиар буурсан. Гэмт хэргийн илрүүлэлт 19,7 хувь байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 6,9 хувиар өссөн эерэг үзүүлэлттэй байна.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ЭРҮҮГИЙН ЦАГДААГИЙН АЛБА
**ШИНЭ САНАЛ САНААЧИЛГА, ТЭРГҮҮН ТУРШЛАГА
БОЛСОН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ**

У.А.П.Д.А.А.Ц.А.Г.Д.А.А.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн А/205 дугаар тушаалаар батлагдсан “Илрүүлэлт-Оргодол-Шийдвэрлэлт” нэгдсэн арга хэмжээний удирдамж, төлөвлөгөөний дагуу алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсүүдээс 2019 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 2019 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион явуулсан.



ХҮРСЭН ҮР ДҮН:

Нэгдсэн арга хэмжээний хүрээнд өгсөн мэдээгээр ажиллагааны явцад илрүүлсэн 4310 гэмт хэргээс хүнийг санаатай алах 46, хулгайлах 1380, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 1324, залилах 825, дээрэмдэх 134, хүчиндэх 65, бусад 436 хэрэг илрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс илрүүлэлт 7,6 хувиар өссөн. Нийт гэмт хэрэг 3869 буюу 11,4 хувиар буурсан байна.

Эрэн сурвалжлах чиглэлээр олж тогтоосон оргодол 171 буюу 101 нэгжээр, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 1209 нэгжээр тус тус буурсан боловч энэ онд явагдсан нэгдсэн арга хэмжээний төгсгөлд 134 оргодол, 556 сэрдэгдсэн этгээдийн үлдэгдэлтэй байгаа нь өмнөх оны нэгдсэн арга хэмжээний төгсгөлөөс оргодол 34, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 242 нэгжээр бага үлдэгдэлтэй, илрүүлсэн хэрэг өмнөх оны арга хэмжээний үед 9267 байсан бол энэ онд 398 нэгжээр буюу 9665 байгаа нь 4,4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.




ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ЭРҮҮГИЙН ЦАГДААГИЙН АЛБА

ШИНЭ САНАЛ САНААЧИЛГА, ТЭРГҮҮН ТУРШЛАГА БОЛСОН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

Гэмт хэргийн тоо бүртгэлийн сангаас эрүүгийн мөрдөгч нарын илрүүлж, шийдвэрлэсэн хэргийн тоо мэдээг гаргах боломжгүй байгаа нь тухайн алба хаагчийн ажлын үзүүлэлтийг бодитой гаргаж дүгнэхэд хүндрэл учрах, улсын хэмжээний гэмт хэргийн статистик мэдээтэй зөрөх зэрэг асуудлуудыг шийдвэрлэхээр одоогоор ашиглагдагдахгүй байгаа “2105” буюу “Нөхөн илрүүлсэн хэрэг, эрэн сурвалжилж олж тогтоосон этгээд” гэсэн маягтын мэдээллийг өөрчилж “Илрүүлж мөрдөн байцаах албанд шилжүүлсэн” гэх нэршилтэйгээр шинэ маягт бий болгох саналыг ЦЕГ-ын удирдлагад танилцуулсан.

“2105” буюу “Нөхөн илрүүлсэн хэрэг, эрэн сурвалжилж олж тогтоосон этгээд” гэсэн маягтыг шинээр боловсруулж Цагдаагийн байгууллагын дотоод сүлжээний <http://crime.police.gov>, <http://apps.police.gov> хаягуудад тус тус байршуулж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын Эрүүгийн цагдаагийн тасгийн дарга нарт хянах эрх, мэдээлэл судалгааны мэргэжилтэн нарт төвлөрсөн тоо бүртгэлд авах эрх олгоод байна.



ХҮРСЭН ҮР ДҮН:

Аливаа эрүүгийн хэрэгт зөвхөн нэг идэвхтэй 2105 маягт бүртгэх, цагдаагийн байгууллагын аль ч нэгжийн шалгаж буй эрүүгийн хэргийг илрүүлж, мөрдөн байцаах албанд шилжүүлэх, хариуцсан ажилтныг солиход тухай хэргийг илрүүлсэн алба хаагчийн мэдээллийг өөрчлөхгүйгээр хадгалах зэрэг давуу талтай төдийгүй улсын хэмжээнд статистик тоон мэдээ гаргах, Эрүүгийн цагдаагийн албаны алба хаагчдын ажлыг үнэн зөв, бодитой дүгнэх, нөхцөл боломжийг бүрдүүлсэн. Эрэн сурвалжлах чиглэлээр олж тогтоосон оргодол 171 буюу 101 нэгжээр, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 1209 нэгжээр тус тус буурсан боловч энэ онд явагдсан нэгдсэн арга хэмжээний төгсгөлд 134 оргодол, 556 сэрдэгдсэн этгээдийн үлдэгдэлтэй байгаа нь өмнөх оны нэгдсэн арга хэмжээний төгсгөлөөс оргодол 34, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 242 нэгжээр бага үлдэгдэлтэй, илрүүлсэн хэрэг өмнөх оны арга хэмжээний үед 9267 байсан бол энэ онд 398 нэгжээр буюу 9665 байгаа нь 4,4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ЭРҮҮГИЙН ЦАГДААГИЙН АЛБА
**ШИНЭ САНАЛ САНААЧИЛГА, ТЭРГҮҮН ТУРШЛАГА
БОЛСОН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ**

У.А.П.О.А.А.С.Б.М.

Цагдаагийн байгууллагын 100 ойг тохиолдуулан “Монгол цагдаа-100” ойн тэмдэгийг хийлгэж, үнэмлэх туузын загварыг батлуулсан.

Тэмдэгийн загварыг Соёлын тэргүүний ажилтан, дизайнер, зураач Ц.Тамир, урлаг судлаач Ж.Бат-Ундар нартай хамтран боловсруулж, Монгол Улс, Франц Улсын ардын зураач, Урлагийн гавьяат зүтгэлтэн Б.Чогсом, Урлагийн гавьяат зүтгэлтэн, зураач Г.Дунбүрээ нар зөвлөхөөр ажилласан.

Байгууллагын үүрэг чиглэл, сүр хүч, бат бэх байдлыг илтгэж бамбай хэлбэрт оруулан зохиомжилж Монгол утга билэгдэл бүхий сүлд тэмдгээр чимэглэн бүтээсэн.



ХҮРСЭН ҮР ДҮН:

Цагдаагийн байгууллагын 100 ойн хүрээнд цагдаагийн байгууллагад ажиллаж нийт албан хаагч, ажилтнуудад уг тэмдгийг өгөхөөр 15.000 ширхэгийг захиалаад байна.

МОНГОЛ ЦАГДАА

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ЭРҮҮГИЙН ЦАГДААГИЙН АЛБА
**ШИНЭ САНАЛ САНААЧИЛГА, ТЭРГҮҮН ТУРШЛАГА
БОЛСОН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ**

Цагдаагийн байгууллагын 100 ойг тохиолдуулан цагдаагийн байгууллагын бэлэг тэмдэг болсон “Монгол цагдаа-100” логог зохион бүтээлгэсэн.

100-н жил тэгш ойн утгыг Монгол Улсын төрийн далбаанд суулгаж өгснөөр логоны ерөнхий хэлбэр, зохиомж бүтсэн.

Уйгаржин Монгол тоогоор 1921-2021 оныг бичсэн нь арван тавны цагдаа гэсэн утга хадгалж байна.



ХҮРСЭН ҮР ДҮН:

Цагдаагийн байгууллагын бэлэг тэмдэг болсон Логог бүтээлгэсэн цагаас эхлэн цагдаагийн байгууллагын бүхий л үйл ажиллагаанд хэрэглэж, алба хаагч нар дээдэлж ирсэн.

МӨРДӨН БАЙЦААХ АЛБАНААС ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА НЭВТРҮҮЛЭН ХЭРЭГЖҮҮЛЖ, ҮР ДҮНД ХҮРСЭН АЖЛЫН ТУРШЛАГА

МОНГОЛ ЦАГДАА

1. “Шилдэг мөрдөгч” тэмцээн: “Мэргэжлийн улсын аварга” шалгаруулах тэмцээнийг анх Цагдаагийн ерөнхий газрын дэд, Улсын Мөрдөн байцаах газрын дарга асан, цагдаагийн хурандаа Д.Алтангэрэлийн санаачлагаар мөрдөн байцаах албыг сурталчлах, алба хаагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, тэднийг идэвхжүүлэх, тэргүүний мөрдөн байцаагчийг шалгаруулах зорилгоор 1993 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 24 дүгээр тушаалаар зохион байгуулахаар тогтож, анхны тэмцээнийг 1993 оны 09 дүгээр сарын 09, 10-ны өдрүүдэд зохион байгуулж, 29 мөрдөн байцаагч оролцож байсан түүхтэй. Тус тэмцээний шүүгч нарын бүрэлдэхүүнийг ЦЕГ-ын дэд дарга, УМБГ-ын дарга, цагдаагийн хурандаа Д.Алтангэрэлийн 1993 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 264 дүгээр тушаалаар томилж шүүгч нарын зөвлөлийн даргаар УМБГ-ын Тэргүүн дэд дарга, цагдаагийн дэд хурандаа С.Дамдин томилогдон ажиллаж байжээ. Тэмцээн 1993 оноос 2 жилд нэг удаа, 3 жилд нэг удаа нийт 18 удаа зохион байгуулагдсан бөгөөд 2015 оноос жил бүр зохион байгуулагдаж байна.

Мэргэжлийн аварга шалгаруулах “Шилдэг мөрдөгч-2020” тэмцээнд нийт 54 мөрдөгч оролцсон нь хамгийн олон оролцогч хамрагдсанаараа онцлог болсон ба тэмцээний ач холбогдол нь мөрдөгчдийн мэдлэг ур чадвар дээшилж, харилцан туршлага солилцох, албаараа бахархах сэтгэлгээг бий болгож, мэргэшсэн алба хаагчийг бий болгоход оршино.


Ажил мэргэжлийн аварга 1984



ШИЛДЭГ МӨРДӨГЧ 2020



2. Мөрдөгч сэтгүүл: Мөрдөн байцаах албанаас алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор “Мөрдөгч” сэтгүүлийг тодорхой төрлийн гэмт хэрэг мөрдөн шалгах ажиллагааны тактик, арга зүй, анхаарах асуудал, аргачлал, Цагдаагийн Ерөнхий газраас дэвшүүлсэн зорилт, ажил дүгнэх шалгуур үзүүлэлт, тухайн жилд хэрэгжүүлсэн онцлог үйл явдлуудын талаархи мэдээллүүдийг багтаан 1996 оноос хойш 25 дахь жилдээ 19 дугаарыг хэвлэн алба хаагчдын хүртээл болгож хэвшсэн.




3. ДХИС-тай хамтран ажилласан талаар: Мөрдөгчид тавигдаж буй шаардлагыг үндэслэн тэдний мэргэжлийн мэдлэг, ур чадварын түвшинг хамтран тогтоож, хэрэгцээ шаардлагатай давтан, мэргэшүүлэх, зайн сургалтыг зохион байгуулах, "Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт"-ын чиглэлээр үйлдвэрлэлийн дадлага хийсэн сонсогч, суралцагчдын дадлагын тайлан хамгаалуулахад хамтран ажиллах, ахиц дэвшил, алдаа дутагдлыг хамтран хэлэлцэх, цаашид хэрэгжүүлэх ажил арга хэмжээг зохион байгуулах, эрдэм шинжилгээ, судалгаа, сургалтын үйл ажиллагааны чиглэлээр Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үр ашигтай хамтран ажиллах зорилгоор Дотоод хэргийн их сургуультай **"Хамтран ажиллах санамж бичиг"** байгуулан жил бүр удирдамжийн дагуу ажил, арга хэмжээг хэрэгжүүлснээр Мөрдөн байцаах албаны хүний нөөцийн тогтвортой байдал хангагдаж байна.



4.True conference: Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 23.3 дугаар зүйлд заасан “Хэргийн газрын үзлэг”-ийг чанартай гүйцэтгэж ул мөр, эд мөрийн баримт илрүүлж бэхжүүлэх ажиллагаанд ахиц гаргах, мөн хуулийн 16.2 дугаар зүйл “Нотолбол зохих байдал”-ыг бүрэн нотлох, 6.3 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг “Мөрдөн шалгах ажиллагааг зохион байгуулалтын болон мэргэжлийн удирдлагаар хангах замаар гэмт хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох талаар шуурхай зохицуулалт хийх” гэж заасны дагуу хүнд гэмт хэргийн газарт ажиллаж байгаа алба хаагчдын үйл ажиллагааг дуу дүрсний бичлэгээр хянаж мэргэжлийн удирдлагаар ханган ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэх зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албатай хамтран “TrueConf” хөдөлгөөнт төхөөрөмжийг 2019 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Санхүү аж ахуйн албанаас “Samsung X Cover” маркийн 2172 ширхэг гар утсыг нутаг, дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсүүдэд хүргүүлж үйл ажиллагаандаа ашиглан 2015 хэргийн газрын үзлэгийг хянаж, зааварчлан ажилласнаар хүнд гэмт хэргийн газрын үзлэгийн чанар дээшилж, хэргийн илрүүлэлт өмнөх оныхоос 2,2 хувиар өсөөд байна.



5. Ятгах тусам нягтал арга хэмжээ: Мөрдөн байцаах албанаас Монгол банк, Монголын банкуудын холбоотой хамтарч Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Ятгах тусам Нягтал” арга хэмжээг 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 02 дугаар сарын 01-ний өдөр хүртэл улсын хэмжээнд зохион байгуулж, богино хэмжээний дүрст бичлэг 10, радио шторк 10, зурагт хуудас 10 сэдвээр тус тус бэлтгэн, 6,675 ширхэг зурагт хуудас, “Ятгах тусам Нягтал” “залилагчид боломж бүү олго” үгтэй 100 ширхэг самбар хэвлүүлэн, нэгжүүдэд хүргүүлсэн.

Иргэдэд залилах гэмт хэргийн нөхцөл байдал, хор уршиг, түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл хүргэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, иргэдэд 1024 удаа сургалт зохион байгуулж, 115,122 хүнийг хамруулж, дүрст бичлэг, радио шторк, зурагт хуудсыг 253 удаа телевизээр, 76 удаа фм радиогоор нэвтрүүлэн, лед дэлгэц, зам дагуух самбар, автобусны буудал зэрэг 1653 байршилд, нийтийн цахим сүлжээнд 4809 мэдээлэл байрлуулан иргэдэд хүргэсэн.

“МҮОНРТ”, “Монгол HD”, “TV5”, “UBS”, “SBN” зэрэг 62 телевиз, 45 сонин сэтгүүл, 82 вэб сайтад зорилтот нэвтрүүлэг 50, зочны цаг нэвтрүүлэг 44, бодит мэдээ сурвалжлага 19 бэлтгэн, 112 удаа ярилцлага өгч, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, инстаграм, твиттер, фэйсбүүк, youtube хуудаст оруулсныг давхардсан тоогоор 8,740,231 хүн үзэж, 860,150 хүн бусадтай хуваалцаж, 1,125,128 хүнд таалагдсан байна.

“Ятгах тусам Нягтал” нөлөөллийн арга хэмжээний үр нөлөөг тоон болон чанарын аргаар тодорхойлох, иргэдэд бодитойгоор нөлөөлсөн эсэхэд дүн шинжилгээ хийж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, зөвлөмж боловсруулах зорилгоор Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн эрдэмтэн багш нараар криминологи судалгаа хийлгэхэд Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлд заасан “залилах” гэмт хэрэг улсын хэмжээнд энэ оны 1 дүгээр сард 543 бүртгэгдсэн нь өмнөх оны 1 дүгээр сартай харьцуулахад 15.3 хувиар буюу 98 хэргээр буурсан байна.



6. Мөрдөн байцаах алба, “Солушн менежмент” групп, “Жи мобайл” групп, Олон улсын “Жи Си Ай” төрийн бус байгууллагатай хамтран алба хаагчдын стрессийг бууруулах, удирдлагын манлайллыг дээшлүүлэх зорилгоор **“Өөрийгөө хөгжүүлж, иргэддээ үлгэрлэе”** хөтөлбөрийг 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 долоо хоногийн турш Zoom аппликейшн ашиглан ажлын төлөвлөлт, цагийн менежментийг сайжруулах, зөв дадал зуршил, тамхи, согтууруулах ундаанаас татгалзах, мэдлэг чадвараа дээшлүүлэх, санхүүгийн сахилга баттай болох, ар гэртээ тавих халамжаа ухамсарлан, ажилдаа хандах эерэг хандлагыг бий болгох сургалтуудыг цахим хэлбрээр явуулж, үр дүнг тооцох “Сэтгэл ханамж”-ийн судалгааг авахад оролцогчдын 92.4 хувь нь цаг үеэ олсон, алба хаагчдын хэрэгцээ шаардлагад нийцсэн хөтөлбөр болсон гэж дүгнэсэн.

Уг төсөл нь 2020 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр “JCI WORLD CONGRESS 2020- BEST LOCAL SOCIAL RESPONSIBILITY PROJECT” буюу “ХАРИЛЦАА ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ШИЛДЭГ” төслөөр шалгарч тэргүүн байр эзэлсэн нь төслийн цар хүрээ, нэр хүндийг илтгэж байна.

Мөрдөн байцаах алба



Чанартай боловсон хүчин бэлтгэх зорилгоор Дотоод хэргийн их сургуультай байгуулсан **“Хамтран ажиллах санамж бичиг”**-ийн хүрээнд “Цагдаагийн ажил-эрх зүй” хөтөлбөрийн төгсөх дамжаа, эчнээ дамжааны суралцагчдын үйлдвэрлэлийн дадлагыг тус албанаас зохион байгуулж, суралцагчдын тайланг хамгаалуулах ажлыг 2018 оноос хойш зохион байгуулж хэвшсэн. Мөн Цагдаагийн сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгсөж, тус албаны харьяа нэгжүүдэд шинээр томилогдсон алба хаагчдад тухай бүрт нь хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулж, ахмад ажилтнуудаар мөрдөн байцаагчийн ажлын онцлог, өөрийн ажлын дадлага туршлагын талаар, албаны чиг үүргийн хэлтсийн дарга нараас хэлтсийнхээ ажлын онцлог болон өөрсдийн сонсогч, мөрдөн байцаагчаар ажиллаж байсан үеийг шинэ залуу мөрдөгч нарт танилцуулж, мөрдөгч нарт зориулсан гарын авлага, сургалтын видео хичээлийг гардуулж байна.

НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ ХАМГААЛАХ, ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АЛБА НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ ХАМГААЛАХ ГАЗАР

ЭРГҮҮЛ, ХАМГААЛАЛТЫН ГАЗРЫН ДИПЛОМАТ БАЙГУУЛЛАГА, БАНКНЫ ХАМГААЛАЛТЫН ХЭЛТЭСН

1
 2
 3
 4
 5
 6
 7
 8
 9
 10
 11
 12
 13
 14
 15
 16
 17
 18
 19
 20
 21
 22
 23
 24
 25
 26
 27
 28
 29
 30
 31
 32
 33
 34
 35
 36
 37
 38
 39
 40
 41
 42
 43
 44
 45
 46
 47
 48
 49
 50
 51
 52
 53
 54
 55
 56
 57
 58
 59
 60
 61
 62
 63
 64
 65
 66
 67
 68
 69
 70
 71
 72
 73
 74
 75
 76
 77
 78
 79
 80
 81
 82
 83
 84
 85
 86
 87
 88
 89
 90
 91
 92
 93
 94
 95
 96
 97
 98
 99
 100

1921 оны 7 дугаар сарын 19-нд Ардын цагдан сэргийлэхийг анх байгуулсан өдрөөс харуул хамгаалалтын ажил эхэлсэн бөгөөд 1923 онд Оросын консулыг хамгаалж байжээ. Ийнхүү элчин консулыг хамгаалтанд авснаар Монгол Улсад гадаад орнуудын дипломат төлөөлөгчийн газруудын харуул, хамгаалалтын үйл ажиллагаа явуулж ирсэн цагдаагийн байгууллагын түүхэн замнал эхлэн өнөөдрийг хүртэл 98 жил үйл ажиллагаа явуулж байна.

**ШИНЭ САНАЛ САНААЧИЛГА, ТЭРГҮҮН ТУРШЛАГА
БОЛСОН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ**

Тус газарт шаардлагатай техник хэрэгсэл /компьютерын микрофонтой камер, спикер, usb sound/-ийг бэлтгэж Төмөр замын цагдаагийн газартай цахим сүлжээгээр холбогдон мэдээ, мэдээлэл, удирдлагаас өгсөн үүрэг, чиглэл, сургалт авах зэрэг боломжийг бүрдүүлж 13 өртөө, зөрлөгийн алба хаагчдад дүрст хурал, зайн сургалт явуулахад бүрэн боломжтой “TRUE CONF” програм хангамжийг суулган зохих тохиргоог хийн бүрэн нэвтрүүлсэн. 2020 онд

Мэдээ, мэдээллийн цахим сүлжээгээр авах зорилгоор газрын хурлын өрөөнд “TRUE CONF” програм хангамжаар цахим хурал явуулахад шаардлагатай техник хэрэгслийг авч зохих тохиргоог хийн Цагдаагийн ерөнхий газар болон бусад албадаас зарласан мэдээ, мэдээлэл, үүрэг, чиглэлийг, 7 хоног бүрийн даваа, лхагва, баасан гарагт Тээврийн цагдаагийн албанаас зохион байгуулагддаг нэгдсэн хурлыг онлайнаар хүлээн авахад техник хэрэгслийн бэлэн байдлыг ханган ажиллаж байна




ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН САНХҮҮ, АЖ АХУЙН АЛБА

**ШИНЭ САНАЛ САНААЧИЛГА, ТЭРГҮҮН ТУРШЛАГА
БОЛСОН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ**

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад нийт 1200-аад автомашин данс бүртгэлтэй байгаагаас нийт автомашины 60 орчим хувь нь Улаанбаатар цагдаагийн хүрээний байгууллагад, 40 орчим хувь нь нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсүүдэд ашиглагдаж байна.

Нийт автомашины 28 хувь нь 0-5 жил ашиглагдаж байгаа шинэ, 41 хувь нь 6-10 жил ашиглагдаж байгаа цаашид ашиглах боломжтой, 31 хувь нь 11-ээс дээш жил ашиглагдаж байгаа шинэчлэх шаардлагатай тээврийн хэрэгсэл байна.

Цагдаагийн байгууллагад ашиглагдаж байгаа
автомашинны насжилт



CARNIVAL



K5



Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолын жишиг норматив, хугацаа норм дууссан автомашиныг шинэчлэх шаардлагатай байгаа ба нөхөн хангалтад 38,4 тэрбум төгрөг шаардлагатай тооцоо судалгааг Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яаманд жил бүр уламжилж, эдийн засгийн нөхцөл байдлын улмаас шийдвэрлэгдээгүй.

“Цагдаагийн байгууллагын түүхт 100 жилийн ойн баяр” энэ онд тохиохтой холбогдуулан олон улсын цагдаагийн байгууллагад хэрэгжүүлдэг түрээсийн үйлчилгээний схемийг Монгол Улсад анх удаа хэрэгжүүлэх “Санхүүгийн түрээсийн үйлчилгээ авах журам”-ыг боловсруулан Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/96 дугаар тушаалаар батлуулж, өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглах 5 нэр төрлийн 350 автомашиныг 3-4 жилийн хугацаанд түрээслэхээр гэрээ байгуулан автомашины 30 орчим хувийг шинэчлэхээр бэлтгэл ажлыг хангаад байна.

Ингэснээр хуулиар хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүргээ хэрэгжүүлэхэд томоохон ахиц дэвшил бий болж, албаны шуурхай бэлэн байдал хангагдана гэж үзэж байна.

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН САНХҮҮ, АЖ АХУЙН АЛБА
ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН БАРИЛГА
БАЙГУУЛАМЖИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ**



ЦЕГ-ын барилга нь зорьтой 6 давхар 6585 м.кв талбайтай Чингэлтэй дүүргийн 4-р хороонд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 7,500.0 сая төгрөгөөр 2014 онд барьсан.

Мөрдөн байцаах албаны барилга зорьтой 9 давхар 6895 м.кв талбайтай Чингэлтэй дүүргийн 4-р хороо улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 9,200.0 сая төгрөгөөр 2018 онд барьсан.



Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн барилга нь зорьтой, 6 давхар, 2672 м.кв талбайтай, Сүхбаатар дүүргийн 2019-2021 он, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 4,115.0 сая төгрөгөөр барьсан.



Нэг маягийн зураг төслөөр Улаанбаатар хотын цагдаагийн 2, 3 дугаар хэлтсүүд, Баянхонгор, Хэнтий, Өвөрхангай, Дундговь, Говь-Алтай аймаг дахь цагдаагийн газруудын барилгуудыг 2014-2019 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтад оруулсан.

Улсын төсвийн 2021-2022 оны хөрөнгө оруулалтаар Сүхбаатар, Говьсүмбэр аймаг дахь цагдаагийн газар, хэлтсийн барилгыг барихаар төлөвлөж байна.



Цагдаагийн ерөнхий газар, алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагууд алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор 2007-2021 онд нийт 3600 гаруй алба хаагчдыг зах зээлийн ханшнаас хямд үнэтэй орон сууцаар хангасан.

У.А.Д.М.А.А.С.Б.М.

ЭКОЛОГИЙН ЦАГДААГИЙН АЛБА “БАЙГАЛЬ ЭН ТЭРГҮҮНД” ТӨСӨЛ 2020 ОН

УСДМБААЦБМ

Тус төслийн хүрээнд “Таны дуу хоолой байгалийг хамгаалж чадна” уриа дор “Ногоон дуу хоолой”, иргэд, олон нийтэд хог хаягдлын талаар мэдээлэл өгөх, хөрс, усны бохирдлын эх үүсвэрийг бууруулах чиглэлээр “Хогоор бүү хорло”, аялал жуулчлалаас үүдэлтэй хүрээлэн байгаа орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр “Ирлээ, Явлаа, Цэвэр”, байгаль орчныг хамгаалах тухай багц хуулийн хэрэгжилтийг хангах, байгалийн нөөц баялаг, биологийн олон янз байдлыг хамгаалах, нөхөн сэргээх, зүй зохистой ашиглах, эзэмшихтэй холбоотой гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, иргэдийн эрх зүйн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх зорилгоор “Цэнхэр алт усаа хайрлая”, “Ой модоо хайрлая” нөлөөллийн аянуудыг тус тус зохион байгуулснаар иргэд, олон нийтийн байгаль орчинтой зөв харьцах, хамгаалах мэдлэг ойлголт, боловсролыг дээшлүүлж, зөв үйлдэлд уриалж сэдэлжүүлсэн нийтийн дэмжлэг авсан нийгмийн захиалгат ажил, арга хэмжээ болсон.



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН БҮРТГЭЛ ХЯНАЛТЫН ТӨВ

**ШИНЭ САНАЛ САНААЧИЛГА, ТЭРГҮҮН ТУРШЛАГА
БОЛСОН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ**



Замын хөдөлгөөний хууль, дүрмийн цахим шалгалтын танхимд иргэний бүртгэл мэдээллийг “Хур” системд холбож хурууны хээ уншигч төхөөрөмж болон компьютер тус бүрт веб камерыг байрлуулж шалгалтын үйл явцыг гэрэл зургаар баталгаажуулж, шалгуулагч тэнцсэн болон тэнцээгүй тохиолдол болгонд тухайн иргэний зургийг жолоочийн үнэлгээний хуудсанд хэвлэснээр, бусдын өмнөөс шалгалт өгөх боломжгүй болж дүнд нөлөөлөх хувь хүний хамаарлыг арилган алба хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тэдний аюулгүй байдлыг хангах ач холбогдолтой ажил болсон.

Галт зэвсэг болон түүнтэй адилтгах хэрэгсэл худалдан авч буй иргэд тус төвд холбогдох материалыг бүрдүүлсний дараа Нийслэлийн цагдаагийн удирдах газарт ижил материал бүрдүүлж гэрчилгээ авах нь ажлын давхардал үүсч иргэдэд чирэгдэл учирч байсныг дээрх үйлчилгээг чирэгдэлгүй, түргэн шуурхай, тэдэнд илүү ойртуулах, нэг цэгт төвлөрүүлэх зорилгоор холбогдох танилцуулга, үндэслэлийг Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад танилцуулж шийдвэрлүүлснээр галт зэвсэг худалдан авах, бүртгэх, гэрчилгээ олгох, Гэрээт харуул хамгаалалт, хувийн хамгаалалтын тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг улсын хэмжээнд хангуулах, зөвшөөрөл олгох, хяналт тавих чиглэлийн ажлын байр нэг цэгт төвлөрч, иргэн, аж ахуйн нэгжид цагдаагийн байгууллагаас үзүүлж буй бүх төрлийн үйлчилгээг үзүүлж байна.



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН БҮРТГЭЛ ХЯНАЛТЫН ТӨВ

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ХАР ТАМХИТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР**

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
 ХАР ТАМХИТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдох, хэрэглэгч, донтогч болох эрсдэлтэй, зорилтот бүлгийн хүүхэд, залуучууд болох 13-25 насныханд чиглэсэн ажил, арга хэмжээ бүхий “Хасах 25” төслийг 2020 оны 06 дугаар сарын 16-ны өдөр ЦЕГ-ын даргаар батлуулан төлөвлөгөөний дагуу 13-25 насны хүүхэд, залуучуудын дунд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, түүний хор уршиг, үр дагаврын тухай ойлголт, мэдлэг, хандлага, хэрэглээний тархалтын талаарх судалгааг мэргэжлийн байгууллагатай хамтран хийж, Нийслэлийн ерөнхий боловсролын дунд сургуулийн 11-12 ангийн хүүхдүүдэд эрүүл амьдралын хэв маяг, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ, хорт зуршлын сөрөг үр дагаврын талаар мэдлэг олгох урьдчилан сэргийлэх сургуульд суурилсан ухуулга нөлөөллийн сургалтыг зохион байгуулах, зорилгоор тус газраас 10 сургагч багшийг хөтөлбөрийн дагуу бэлтгэж, зорилтот бүлгийн хүүхэд, залуучуудтай ажилладаг ерөнхий боловсролын сургууль, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, их, дээд сургуулийн багш, нийгмийн ажилтнуудыг чадавхжуулах, Олон улсад амжилттай хэрэгжиж, үр дүнгээ өгч байгаа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтээс урьдчилан сэргийлэх стандарт, хөтөлбөрийг өөрийн орны онцлог, зан заншил, хэв маягт нийцүүлэн нутагшуулах зэрэг ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна.



ХҮРЭХ ҮР ДҮН:

Энэ төсөл нь 25 хүртэл насны хүүхэд, залуучуудын дунд мансууруулах бодисын ойлголт хандлага, хэрэглээний тархалтыг судлах, судалгаанд суурилсан үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах, өсвөр үе, залуучуудыг нийгмийн бүхий л харилцааны үед энэ төрлийн гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН БҮРТГЭЛ ХЯНАЛТЫН ТӨВ

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
“ХҮЧ” СПОРТ ХОРОО**



1. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын 25 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх төв комиссын хурлын 1946 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 06 дугаар тогтоолоор “Хилчин” нийгэмлэг нэртэй байгуулагдсан нь одоогийн Цагдаагийн ерөнхий газрын “Хүч” спорт хорооны үндэс суурь юм. Өдгөө 75 жилийн түүхтэй тус спорт хороо нь Дэлхийн цагдаагийн спортын болон Олон Улсын Динамо нийгэмлэгүүдийн гишүүн байгууллага бөгөөд Монгол Улсад нийтийн биеийн тамир, их спортыг хөгжүүлэх, тив, дэлхий, олимпын наадамд өрсөлдөх тамирчид бэлтгэх, албаны болон их спортоор дамжуулан Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын бие бялдрыг хөгжүүлж, албаны бэлэн байдлыг хангах зорилготой үйл ажиллагаагаа явуулж байна.

Хүрсэн үр дүн: Цагдаагийн ерөнхий газрын “Хүч” спорт хорооноос Монгол Улсын Хөдөлмөрийн баатар-2, ардын багш-2, соёлын гавьяат зүтгэлтэн-1, гавьяат дасгалжуулагч-5, тамирчин-30, олон улсын хэмжээний мастер-60, спортын мастер, дэд мастер-850, олон улсын шүүгч-4, улсын шүүгч-75 төрөн гарч, төрийн дээд шагналаар 85 тамирчин, дасгалжуулагч, алба хаагч шагнуулсан төдийгүй 1990-2015 онуудад 31 тамирчин “Монгол Улсын оны шилдэг тамирчин”-аар шалгарсныг үнэлж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 07 дугаар сарын 03-ны 164 дүгээр зарлигаар “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-гоор шагнасан.

2. Цагдаагийн ерөнхий газрын “Хүч” спорт хорооноос олимпын өвлийн наадамд 6, зуны наадамд 13, өсвөр, оюутан, залуучууд, ахмадын дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд давхардсан тоогоор 78 алба хаагч, тамирчин бэлтгэн оролцуулсан.

Хүрсэн үр дүн: Зуны олимпын наадамд 3 удаагийн шагналт байр, дэлхийн аварга шалгаруулах тэмцээний “Самбо бөх”-ийн 34 алт, 42 мөнгө, 27 хүрэл, “Байлдааны самбо бөх”-ийн 2 алт, 2 мөнгө, 4 хүрэл, “Жүдо бөх”-ийн 2 алт, 4 хүрэл, “Чөлөөт бөх”-ийн 5 алт, 6 мөнгө, 9 хүрэл, “Хөнгөн атлетик”-ийн 1 алт, “Бокс”-ын 1 алт, 1 мөнгө, 1 хүрэл, “Кик бокс”-ын 3 алт, 3 мөнгө, 3 хүрэл, “Кураш бөх”-ийн 2 алт, “Гардан тулаан”-ы 2 мөнгө, “Шатар”-ын 1 мөнгө, “Таеквондо”-гийн 1 алт, 2 мөнгө, 1 хүрэл, “Буудлага”-ын 1 мөнгөн медаль тус тус хүртсэн.

3. Монголын ард түмний уламжлал, зан заншилд тулгуурлан хөгжсөн үндэсний спортын өв уламжлалыг хадгалах, хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх үйлсэд үүссэн цагаасаа анхаарал тавьж, Тулгар төр, Их Монгол улс, ардын хувьсгалын түүхт ойн үндэсний их баяр наадамд цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагч, тамирчдыг бэлтгэн оролцуулж байна.

Хүрсэн үр дүн: Үндэсний бөхийн төрөлд Монгол Улсын дархан аварга-3, аварга-2, арслан-6, гарьд-2, заан-13, харцага-10, начин-51, үндэсний сур харвааны төрөлд Монгол Улсын даяар дуурсагдах дархан мэргэн-1, улсын мэргэн 1 тус тус төрөн гарсан.

4. Цагдаагийн ерөнхий газрын “Хүч” спорт хорооны дасгалжуулагч, цагдаагийн ахмад, Монгол Улсын гавьяат тамирчин Мөнхбатын Уранцэцэг нь 2012, 2016 оны Олимпын наадам /Olympic Games/-д 5, 7 дугаар байр, Дэлхийн аварга шалгаруулах /World Championships/ болон Ази тивийн аварга шалгаруулах тэмцээн /Continental Championships/, Дэлхийн цомын тэмцээн /World Cup/, Мастерууд /Masters/ ангилал, Их дуулга /Grand Slam/, Гран при тэмцээн /Grand Prix/-үүдээс нийт 21 алт, 16 мөнгө, 19 хүрэл медаль хүртэж, 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дэлхийд чансаагаараа Жүдо бөхийн эмэгтэйчүүдийн “-48 кг”-ын жинд 4 дүгээр байрт эрэмбэлэгдэж байна.

Хүрсэн үр дүн: Цагдаагийн ахмад М.Уранцэцэг нь 2010 оны 12 дугаар сарын 17-ноос 2019 оны 04 дүгээр сарын 05-ны хооронд Олон Улсын Жүдо бөхийн холбоо (IJF)-ны цуврал Мастерс, Их дуулга, Гран при тэмцээнээс хамгийн олон буюу 11 алт, 11 мөнгө, 13 хүрэл медаль хүртсэнийг 2020 онд “Гиннесийн дээд амжилт”-д бүртгэсэн.

5. Цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ажилтан, хүүхэд, залуучуудыг нийтийн биеийн тамир, спортоор хичээллэх, бие бялдраа хөгжүүлэх, чийрэгжүүлэх нөхцөл боломжоор хангах, ажлын байрны ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор улсын төсвийн 70.5 сая төгрөгийн санхүүжилтээр засвар, тохижилтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Хүрсэн үр дүн: Спортын тэмцээн уралдаан зохион байгуулах, цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ажилтан, хүүхэд, залуучууд нийтийн биеийн тамир, спортоор хичээллэх, бие бялдраа хөгжүүлэх орчин сайжирсан.

ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН СУРГАЛТЫН НЭГДСЭН ТӨВ

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
“ХҮЧ” СПОРТ ХОРОО**



1.Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтэстэй хамтран “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотой хууль тогтоомжийн эмхэтгэл”, “Цагдаагийн албаны тухай хууль тогтоомжийн эмхэтгэл”-ийг тус тус боловсруулж, цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулсан.

2.Цагдаагийн 6 үеийн баримлыг шилэн хоргонд байрлуулж, тус төвийн болон Хээрийн сургалтын хэсгийн үйл ажиллагааг харуулсан лед самбар 10 ширхэгийг хийж, сургалтын танхимд байршуулсан.

3.Хүүхэд, багачуудад цэрэг, эх оронч үзлийг төлөвшүүлэх, ирээдүйд цагдаа, дотоодын цэргийн байгууллагад ажиллах хүсэл, эрмэлзлийг төрүүлэх зорилгоор Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн газартай хамтран төвийн үйл ажиллагаа, бие хамгаалах урлагийн үзүүлэх тоглолт, хэргийн газрын хиймэл орчин, цагдаа, дотоодын цэргийн байгууллагад ашиглаж байгаа галт зэвсэг, тусгай техник хэрэгсэл, үе үеийн албаны дүрэмт хувцас зэргийг тус цагдаагийн газрын алба хаагч, ажилтны хүүхэд, багачуудад сонирхуулсан. Гэмт хэрэгтэй тэмцэх ажилд албаны нохойг хэрхэн ашигладаг талаар мэргэшсэн алба хаагч, сургагч багш нар тусгай хөтөлбөр бэлтгэн сонирхуулсан нь байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан, шинэлэг ажил, арга хэмжээ болсон.

4.Тээврийн цагдаагийн албаны танхимын шалыг шинэчлэн, гэмт хэрэгтэй тэмцэх, галт зэвсгийн танхимд алба хаагчдын сургалтад ашиглагдах малын им, тамга, үүлдэр, зүс, Монгол оронд тархсан үнэт болон хагас үнэт чулуу, мод, ургамлын талаарх мэдээллийг агуулсан 10 зурагт самбарыг байршуулж, албанд ашиглагдаж буй тусгай хэрэгсэл, галт зэвсэг, сум хэрэгсэл түүний хагас задаргаа, тактик техникийн өгөгдөхүүнийг тусгайлан бэлтгэсэн шилэн хоргонд байрлуулсан нь алба хаагчдын хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах мэдлэгийг олгосон, сургалтын материаллаг баазыг нэмэгдүүлсэн чухал ажил болсон.

5.Тус төвийн Нарстай дахь Хээрийн сургалтын хэсэгт 8 буудлагын талбайг шинээр байгуулж, 1 талбайг 100 метр сунган, үер, уснаас хамгаалах даланг босгож, буудлагын талбайн ойр орчмыг тохижуулах, шаардлагатай байгууламжийг барих, засварлах, гэрэлтүүлэг, ариун цэврийн өрөөний асуудлыг шийдвэрлэх зэрэг бүтээн байгуулалтын ажлыг цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчид, удирдлагын дэмжлэгтэйгээр хийж гүйцэтгэлээ. Шинээр байгуулсан буудлагын талбай, орчин нөхцөл нь цаашид Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын алба хаагч, ажилтнууд, иргэдийн галт зэвсэг эзэмших, ашиглах аюулгүй ажиллагааны болон практик буудлага, хамгаалалтын буудлагын дадлага, тактикийн сургалт явуулахаас гадна НҮБ-ын цагдаа /UNPOL/, Зэвсэгт цагдаа /FPU/, Олон улсын цагдаагийн байгууллагын сургалт, олон улс, ази тивийн буудлагын тэмцээн зэрэг томоохон арга хэмжээ зохион байгуулах бүрэн боломжтой бааз суурь болох эхлэл тавигдсан.

6.Сумны хонгио дахин цэнэглэх бага оврын үйлдвэрийг Хээрийн сургалтын хэсгийг түшиглэн байгуулахаар холбогдох тооцоо, судалгаа, санал, танилцуулгыг Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн алба болон бусад мэргэжлийн нэгжүүдтэй хамтран боловсруулж, Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албанд хүргүүлэн төсөв, хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлж, худалдан авалтыг хийсэн бөгөөд 2021 оны 01 дүгээр улиралд ашиглалтад оруулахаар төлөвлөж байна. Сумны хонгио дахин цэнэглэх бага оврын үйлдвэр байгуулснаар төрийн цэргийн болон тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын алба хаагчдын сургалтын хэрэгцээнд ашиглах галт зэвсгийн сум үйлдвэрлэх, сумны нөөцийг бага зардлаар бүрдүүлэх, ашигласан сумны хонгиог дахин цэнэглэж угсрах, галт зэвсэг, сум, тусгай хэрэгсэлд засвар үйлчилгээ хийх, засаж сэлбэх зэрэг нөхцөл боломж бүрдэнэ гэж үзэж байна.

7.Алба хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор фитнесийн техник, хэрэгслийг шинээр худалдан авч, фитнесийн болон ширээний теннисний өрөөг орчин үеийн интерьер, загвараар тохижуулж 10 төрлийн тоног, төхөөрөмжийг 35 сая төгрөгөөр худалдан авч, суурилуулан ашиглалтад

оруулсан. Фитнес спорт заалыг ашиглалтад оруулж, алба хаагчдыг хичээллүүлснээр “Эрүүл цагдаа хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт хангагдаж, алба хаагчдын биеийн тамир, спортоор хичээллэх хүсэл, сонирхлыг нэмэгдүүлэх, бие бялдрыг хөгжүүлж, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх чухал ач холбогдолтой юм.

8. Мөн алба хаагчдын бие бялдрын бэлтгэжилтийг хангах, эрүүл мэнд, тэдний ажиллах орчинг сайжруулах зорилгоор төвийн “Б” байрны 1 дүгээр давхарт саун, душны өрөөг “Буурал чандмань” ХХК-иар 12 сая төгрөгийг төсөвт өртөгтэйгөөр шинээр хийлгүүлж, энэ оны 1 дүгээр улиралд ашиглалтад хүлээн авсан.

9. Алба хаагчдын гадаад хэлний мэдлэгийг сайжруулах, орчин үеийн сургалтын техник, технологийг нэвтрүүлэх зорилгоор тус төвд гадаад хэлний лингафоны болон цахим сургалтын танхимыг шинээр бий болгохоор Цагдаагийн ерөнхий газрын Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтсээр уламжлан АНУ-ын элчин сайдын яаманд 164,4 сая төгрөгийн зураг төсөл, танилцуулгыг 2020 оны 08 дугаар сард хүргүүлж шийдвэрлүүлсэн. Үүний дагуу танхимын засвар, тохижилт, шаардлагатай техник хэрэгслийн талаарх үнийн судалгааг дахин шинэчлэн, АНУ-ын элчин сайдын яаманд хүргүүлж, шаардлагатай техник, хэрэгслийг худалдан авах болон тохижилт, засварын ажлыг энэ оны 04 дүгээр сараас эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

10. Монгол Улсад Хууль зүйн алба үүсэн байгуулагдсаны 110, орчин цагийн цагдаагийн байгууллага үүсэн байгуулагдсаны 100 жилийн ой 2021 онд тохиохтой холбогдуулан 8 метрийн урттай, 3 метрийн өндөртэй зөөврийн тайзыг дотоод нөөц бололцоогоо ашиглан хийж ашиглалтад оруулсан.

11. Иргэний болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалт"-д хамрагдсан иргэдэд олгодог “Гэрчилгээ”-г шинэчилж, хатуу хавтас бүхий тусгай нууцлалтай үнэт цаасан дээр хэвлэн, олгож эхэлсэн нь иргэдийн талархлыг хүлээснээс гадна хуурамчаар үйлдэхээс бүрэн сэргийлсэн.

12. “Иргэний болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалт”, “Гэрээт харуул хамгаалалтын ажилтан бэлтгэх сургалт”, “Харуул хамгаалалтын чиглэлийн албаны нохой бэлтгэх сургалт”-д хамрагдах иргэд, байгууллагад дээрх сургалтуудын талаарх мэдээлэл /хугацаа, давтамж, сургалтад хамрагдахад бүрдүүлэх материал, төвийн хаяг, байршил гэх мэт/-ийг 24 цагийн турш хүргэх IVR /Interactive Voice Response/ буюу автомат хариулагчтай 70190092 суурин утсыг байршуулах ажлыг зохион байгуулж нэвтрүүлсэн. Уг үйлчилгээг нэвтрүүлснээр Цагдаагийн байгууллагын ажил, үйлчилгээг иргэд, байгууллагад шуурхай, хүртээмжтэй хүргэж, иргэдэд чиглэсэн сургалтын талаарх мэдээллийг автомат хариулагчаар 24 цагийн турш өгөх боломжоор бүрэн хангасан.

13. Барилга байгууламжийг гадны аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор гадна талбай, албаны нохойн байр, нохой зугаалуулах хашаа, зочид буудлын үүдний хэсэг, сургалтын хэргийн газрын хиймэл дүрийн орчин зэрэг газруудыг бүрэн хянах зорилгоор нэмэлтээр 14 ширхэг IP камерыг “Ти Жи Эн Эм системс” ХХК-иар, суурилуулж, төвийн жижүүр хяналт тавин ажиллаж байна.

14. Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн 2020 оны 126 дугаар зарлигаар “Үйлчилгээний гавьяат ажилтан” цолоор шагнагдсан Дотоодын цэргийн 805 дугаар ангийн эргүүлчин, ахлах ахлагч Д.Бямбадагва, ЦЕГ-ын Автобаазын цагдаа-жолооч, цагдаагийн ахлах ахлагч Н.Ганхуяг нарыг урьж, тэдний алдрыг мөнхжүүлэх, бие бүрэлдэхүүнд гавьяа зүтгэлийг сурталчлах, туршлага солилцох зорилгоор тус төвийн алба хаагчидтай уулзалт зохион байгуулсан.

15. Албаны нохдыг зөөвөрлөх үеийн аюулгүй байдлыг хангах, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор нэг дор 8 тооны нохой зөөвөрлөх боломжтой тус чиргүүлийг 2019 онд хийж гүйцэтгэн, алба ажиллагаанд ашиглаж байна.

16. Албаны нохдыг аливаа газар оронд удаан хугацаанд үүрэг гүйцэтгэх үед зөөвөрлөн авч явах, аюулгүй байдал, учирч болох эрсдэл, байгалийн хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Канад улсын цагдаагийн нохойн албаны зөөврийн байрнаас туршлага судлан дотоод нөөц бололцоог ашиглан 2019 онд тус зөөврийн нохойн байрыг хийж гүйцэтгэсэн.

17. Албаны нохдыг үүрэг гүйцэтгэх үед тээвэрлэх, аюулгүй байдлыг хангах зорилгоор УАЗ-Фургон маркийн авто машины арын хэсгийг 3 тооны нохойг тусгаарлан тээвэрлэх зориулалттай болгон, мөн нэг дор 8 тооны нохой зөөвөрлөх боломжтой чиргүүл 1, Канад улсын цагдаагийн

нохойн албаны зөөврийн байрнаас туршлага судлан дотоод нөөц бололцоог ашиглан зөөврийн нохойн байрыг 4-ийг тус тус хийж гүйцэтгэн ашиглаж байна.

18. Албаны нохойн сургалтад ашиглагдах сургалтын материалыг нэмэгдүүлэх бусад орны сургалтын арга барилыг нэвтрүүлэх зорилгоор Америкийн Нэгдсэн Улсын нохой сургагч Jeff Schettler –ийн “The straightest path” (Мөрөөр мөрдөх) номыг орчуулуулан “Мөнхийн үсэг” хэвлэлийн үйлдвэрт хэвлүүлэхээр хүргүүлээд байна.

19. Жижүүрийн хяналтад байх зэвсгийн өрөөнд дохиолол, камерын хяналтын систем, төмөр хаалга суурилуулж, өнгөлөн далдлалтын тороор тоноглон, цонхны гадна хэсэгт төмөр хаалт тогтоож, бууны тавиурыг шинээр хийж, “Галт зэвсэг хадгалах, хамгаалах, бүртгэх, биедээ авч явах, олгох журам”-ын дагуу “Галт зэвсгийн өрөө”-г шинээр тохижуулж, ашиглалтад оруулсан.

20. Тээврийн хэрэгсэл ашиглан гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийн гэмт үйлдлийг таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх, Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий нийт цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдад дотоод нөөц боломжоо ашиглан “А”, “В”, “С”, “D”, “E”, “M” ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх олгох, жолоодлогын давтан болон мэргэшүүлэх сургалтыг үе шаттай зохион байгуулах зорилгоор тус төвд “Механикжсан тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх” сургалт явуулах зөвшөөрөл авах хүсэлтийг Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны харьяа Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвд хүргүүлсэн.

21. Иргэний болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах, аюулгүй ажиллагааны сургалт”-д хамрагдсан иргэдийг цагдаагийн байгууллагын цахим мэдээллийн санд бүртгэж, мэдээллийг цахимжуулж байгаа бөгөөд цаашид сургалтад хамрагдсан иргэдийн цахим санг “E-Mongolia” аппликэйшинд холбох чиглэлээр Засгийн газрын тохируулагч агентлаг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газарт хүсэлт хүргүүлж, хамтран ажиллаж байна.

22. Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын алба хаагчдын үр хүүхдэд эцэг, эхийнх нь мэргэжлийн онцлогийг ойлгуулан бахархуулах, тэдэнд эрх зүйн боловсрол олгох, эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилгоор “Оч” хүүхдийн зусланг сэргээн ажиллуулах үндэслэл, шаардлага, шаардагдах төсөв, хөрөнгийн тооцоо судалгааг гарган Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албанд уламжлаад байна.

23. Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2020 оны А/225 дугаар тушаалаар “Сургалт, соёл, спортын цогцолбор”-ыг орчин үеийн интерьер загвар, олон улсын стандартын дагуу байгуулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч, тооцоо судалгаа хийх, зураг төслийг гаргаж, танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан бөгөөд ажлын хэсгээс хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээ, цогцолбор байгуулах газрын асуудлыг шийдвэрлүүлэх санал, танилцуулгыг Хууль зүй, дотоод хэргийн яам, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албанд танилцуулаад байна. Тус цогцолборын талаарх 2 удаагийн танилцуулга 50 ширхэгийг бэлтгэж, хэвлүүлэн Цагдаагийн ерөнхий газрын удирдлага, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны гишүүдэд тус тус хүргүүлсэн.

ЦЕГ-ЫН АВТОБААЗ

**ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГАД АШИГЛАГДАЖ БАЙГАА ОХУ-Д ҮЙЛДВЭРЛЭСЭН
“УРАЛ-375-АМ” МАРКИЙН КОМАНД ШТАБЫН АВТОМАШИНЫ ТАЛААР**

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд команд штабын зориулалтаар ашиглагдаж байгаа Оросын холбооны улсад 1989 үйлдвэрлэсэн “Урал 375 АМ” маркийн автомашины талаар товч танилцуулга.

НЭГ.ОНОЛ, БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ.

Арлын дугаар УРАЛ375399038

Үйлдвэрлэгч УРАЛ Загвар-375-АМ

Төрөл - Ердийн тэвштэй автомашин

Үйлдвэрлэсэн улс – Орос

Үйлдвэрлэсэн он -1989

Өнгө – Хөх алаг

Импортлогдсон огноо: 1983/03/15

Хөдөлгүүрийн багтаамж – 11,150

Шатахууны төрөл – Дизель

Жолооны хүрд – Зүүн

эрчим хүч нь 230 морины хүч, 11,150 литр хэмжээ нь цилиндр 8 байна дизель түлшний үйл ажиллагаа явуулдаг

УМЗ-226 - дизелийн дээр ажиллаж байгаа, 180 морины хүч

УМЗ-НЕ2 236 цахилгаан 230 морины дөрвөн харвалт турбо 11.15 литр хэмжээг байна;

Үүнээс гадна, өөрчлөлт Yaroslavsky индекс 238 М2 236 ВЕ2, 7601. Тэд морины (240 тус тус 250, 300) ялгаатай нь хөдөлгүүрийн үйлдвэр холбогдсон.

ХОЁР. ТОВЧ УТГА, ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.

Энэхүү автомашиныг цагдаагийн байгууллагыг үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх, эрүү, хэв журмын нөхцөл байдал хүндэрсэн, бүх нийтийн хөл хорио тогтоох үед, онцгой нөхцөл бий болсон үед дэг журам сахиулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тактикийн хээрийн сургууль, баяр наадмын хамгаалалт зэрэг чиглэлээр үүрэг гүйцэтгэх зорилгоор хөдөлгөөнт команд штабын автомашины болгон өөрчлөн тоноглож ажил үйлчилгээнд бэлэн болгон ашиглагдаж байна.

ГУРАВ. АГУУЛГА, ШИНЭ САНАА

Цагдаагийн ерөнхий газрын Автобааз нь Оросын холбооны улсад 1989 үйлдвэрлэсэн туулах чадвар сайтай “Урал 375-АМ” маркийн автомашиныг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд команд штабын зориулалтаар ашиглах зорилгоор тусгай техник, тоноглолоор тоноглон албаны болон техникийн бэлэн байдлыг ханган ашиглагдаж байна. Уг автомашинд 6-8 алба хаагчид ажиллах, амарч байрлах 4 ширхэг ор, явуулын нөхцөлд ая тухтай байдлыг хангах зориулалтаар дотор ханыг ширмэл бүрээсээр доторлож, обектыг хянах 4 чиглэлийн хяналтын камер, удирдлагын бүрэлдэхүүн ажиллах компьютер, принтер, хувцасны шкаф, холбоо мэдээллээр хангах зориулалтын холбооны хэрэгслүүд, суурин станц, ажлын ширээ, шаардлагатай тусгай хэрэгсэл багаж хэрэгслийг нөөцлөх 3 нөөцийн сав, шөнийн цагаар үзэгдэх орчны харах хүрээг сайжруулах зорилгоор лед-бар гэрэл, өөрийгөө цахилгаанаар хангах нарны үүсгүүр, 220 вт-ийн цахилгаан үүсгэвэр зэрэг тусгай тоноглолыг суурилуулж, гадна талыг нь POLICE бичиглэл, цагаан, цэнхэр өнгөөр будсан.

У.С.Д.Т.А.А.С.М.



Арын гүүнкний алба хаагч ажиллах, амрах хэсэг.



Дотор талын таазны гэрэлтүүлэг.

НИЙСЛЭЛИЙН ЦАГДААГИЙН УДИРДАХ ГАЗРААС ТҮҮХЭН ХӨГЖЛИЙН ХУГАЦААНД ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА НЭВТРҮҮЛСЭН, ХЭРЭГЖҮҮЛЖ ҮР ДҮНД ХҮРСЭН ШИНЭЛЭГ АЖИЛ, АЖЛЫН ТУРШЛАГА /ИННОВАЦИ/-ЫН ЖАГСААЛТ

Гэмт хэргийн цогц систем /Компстат/ дэд хөтөлбөр:



Г э м т

У.А.Д.М.А.А.С.М.

хэрэг, захиргааны зөрчлийн гаралтын байдалд дүн шинжилгээ хийж эргүүлийн нэгдсэн байршилтыг урьдчилан тодорхойлж, цахим эргүүл ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэхээр гэмт хэргийн цахим зураглал /Compstat-Grime map/-ыг үйл ажиллагаанд нэвтрүүлэн ажиллаж байна. Энэхүү хөтөлбөр хэрэгжсэнээр гэмт хэрэг, зөрчлийг үйлдэгдсэн газар, огноо, эрүүгийн хуулийн зүйл заалт, үйлдэгдсэн өдөр, цаг, авсан арга хэмжээ зэргийг зураглалд нарийвчлан оруулж, гэмт хэрэг, зөрчлүүд ихээр гарч байгаа эмзэг цэгүүдийг тодорхойлох, үйлдэгдэж болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, удирдах албан тушаалтнуудыг нөхцөл байдлаа бодитой, шуурхай хянаж, зөв шийдвэр гаргах, цагдаагийн байгууллагын хүн, хүчийг оновчтой хуваарилах өндөр ач холбогдолтой болсон.

№	Хүснэгт	Төрөл	Тайлбар	Тайлбар	Тайлбар	Тайлбар	Тайлбар	Тайлбар	Тайлбар
44	1000000000	Зөрчил	Хүн амын эрүүл	Иргэдийн хэргийн	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл
45	1000000000	Зөрчил	Хүн амын эрүүл	Иргэдийн хэргийн	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл
46	1000000000	Зөрчил	Хүн амын эрүүл	Иргэдийн хэргийн	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл
47	1000000000	Зөрчил	Хүн амын эрүүл	Иргэдийн хэргийн	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл
48	1000000000	Зөрчил	Хүн амын эрүүл	Иргэдийн хэргийн	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл
49	1000000000	Зөрчил	Хүн амын эрүүл	Иргэдийн хэргийн	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл
50	1000000000	Зөрчил	Хүн амын эрүүл	Иргэдийн хэргийн	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл
51	1000000000	Зөрчил	Хүн амын эрүүл	Иргэдийн хэргийн	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл
52	1000000000	Зөрчил	Хүн амын эрүүл	Иргэдийн хэргийн	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл
53	1000000000	Зөрчил	Хүн амын эрүүл	Иргэдийн хэргийн	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл
54	1000000000	Зөрчил	Хүн амын эрүүл	Иргэдийн хэргийн	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл
55	1000000000	Зөрчил	Хүн амын эрүүл	Иргэдийн хэргийн	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл
56	1000000000	Зөрчил	Хүн амын эрүүл	Иргэдийн хэргийн	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл
57	1000000000	Зөрчил	Хүн амын эрүүл	Иргэдийн хэргийн	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл
58	1000000000	Зөрчил	Хүн амын эрүүл	Иргэдийн хэргийн	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл
59	1000000000	Зөрчил	Хүн амын эрүүл	Иргэдийн хэргийн	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл
60	1000000000	Зөрчил	Хүн амын эрүүл	Иргэдийн хэргийн	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл
61	1000000000	Зөрчил	Хүн амын эрүүл	Иргэдийн хэргийн	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл
62	1000000000	Зөрчил	Хүн амын эрүүл	Иргэдийн хэргийн	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл
63	1000000000	Зөрчил	Хүн амын эрүүл	Иргэдийн хэргийн	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл
64	1000000000	Зөрчил	Хүн амын эрүүл	Иргэдийн хэргийн	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл
65	1000000000	Зөрчил	Хүн амын эрүүл	Иргэдийн хэргийн	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл
66	1000000000	Зөрчил	Хүн амын эрүүл	Иргэдийн хэргийн	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл
67	1000000000	Зөрчил	Хүн амын эрүүл	Иргэдийн хэргийн	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл
68	1000000000	Зөрчил	Хүн амын эрүүл	Иргэдийн хэргийн	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл
69	1000000000	Зөрчил	Хүн амын эрүүл	Иргэдийн хэргийн	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл
70	1000000000	Зөрчил	Хүн амын эрүүл	Иргэдийн хэргийн	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл

№	Хүснэгт	Төрөл	Тайлбар	Тайлбар	Тайлбар	Тайлбар	Тайлбар	Тайлбар	Тайлбар
1	1000000000	Зөрчил	Хүн амын эрүүл	Иргэдийн хэргийн	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл
2	1000000000	Зөрчил	Хүн амын эрүүл	Иргэдийн хэргийн	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл
3	1000000000	Зөрчил	Хүн амын эрүүл	Иргэдийн хэргийн	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл
4	1000000000	Зөрчил	Хүн амын эрүүл	Иргэдийн хэргийн	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл
5	1000000000	Зөрчил	Хүн амын эрүүл	Иргэдийн хэргийн	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл
6	1000000000	Зөрчил	Хүн амын эрүүл	Иргэдийн хэргийн	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл
7	1000000000	Зөрчил	Хүн амын эрүүл	Иргэдийн хэргийн	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл
8	1000000000	Зөрчил	Хүн амын эрүүл	Иргэдийн хэргийн	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл
9	1000000000	Зөрчил	Хүн амын эрүүл	Иргэдийн хэргийн	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл
10	1000000000	Зөрчил	Хүн амын эрүүл	Иргэдийн хэргийн	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл	Хүн амын эрүүл

2

Гэмт хэрэг, зөрчлийн дуудлага, мэдээллийг ECS программд ямар албан тушаалтан хэрхэн шийдвэрлэх, хяналт тавьж удирдлага зохицуулалтаар хангах чиглэлээр “БҮСИЙН ХЯНАЛТ”-ын тогтолцоог 2019 онд туршилтаар нэвтрүүлсэн. Энэхүү ажлын үр дүнд 2019 онд дуудлага, мэдээллийн шийдвэрлэлтэд гарч байсан зөрчил 2020 онд 28 хувиар буурсан эерэг үр дүн гарснаас гадна алба хаагчдын ажлыг үр дүнгээр нь үнэлж, дүгнэх, цахим сан үүсэх боломж нөхцөл бүрдсэн.

Нийслэлийн цагдаагийн удирдах газраас санаачлан Нийслэлийн Засаг даргын тамгын газартай хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Эргүүл”, “Телекамер”-ын дэд хөтөлбөрийг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 62 дугаар тогтоолоор 6 зорилтын хүрээнд 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулсан.

МОНГОЛ ЦАГДАА



3

Морьт эргүүлийг нийслэл хотын ногоон бүс, цэцэрлэгт хүрээлэн, голын эрэг орчим авто болон явган эргүүлийн алба хаагч нар очих боломжгүй, гуу жалга, бартаа саадтай, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж болзошгүй эмзэг цэгүүдэд ажиллуулснаар тухайн бүсэд үйлдэгдсэн гэмт хэрэг 29,7 хувиар буурсан.



4. Дугуйт эргүүлийг хотын барилга, байгууламж, орон сууц ихээр төвлөрсөн, замын хөдөлгөөний ачаалал, түгжрэл дунд авто машин очих боломжгүй газруудад дуудлага, мэдээлэлд богино хугацаанд шуурхай очих нөхцөл бүрдсэн.


5. Монгол Улсын Их Хурлаас 2014 онд батлагдсан Цагдаагийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлд “олон нийтийн цагдаа”-ийн талаар заалт, зохицуулалт тусгагдсаны дагуу дагуу Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолоор 2014 онд 162, 2015 онд 224 олон нийтийн цагдаагийн орон тоотой байхаар баталж, төсөв хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж, нийслэлийн хэмжээнд олон нийтийн цагдаа нарыг ажиллуулж эхэлсэн.



Нийслэлийн 173 хороонд ажиллах олон нийтийн цагдааг 2020 оны 01 дүгээр сард 227 байхаар

орон тоог баталж үүрэг гүйцэтгэж байсан бөгөөд Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2020 оны 03 дугаар сарын 46 дугаар тогтоолоор Нийслэл хотод замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, ачааллыг бууруулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах чиглэлээр ажиллах чадавхыг бэхжүүлэх зорилгоор олон нийтийн цагдаагийн орон тоог 1700-аар нэмэгдүүлж хорооны хэсгийн ахлагч нарыг ажиллуулсан.

6. Нийгмийн идэвхи санаачилгатай иргэдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд татан оролцуулах зорилгоор хэв журмын урамшилт эргүүлийг гудамж талбай, олон нийтийн газруудад ажиллуулсан.



7

Нийслэл хотод аялал жуулчлалаар ирж байгаа гадаадын иргэд, жуулчидад хэрэгцээт мэдээлэл, дэмжлэг тусалцааг шуурхай үзүүлэх зорилгоор “Оюутан цагдаа” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.

Хэв журмын урамшилт эргүүл, Оюутан цагдаагийн тоо санхүүжилтийн улмаас буурсан боловч эргүүлийн үйл ажиллагаанд олон талт арга хэмжээг зохион байгуулж, төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, олон нийтийг татан оролцуулж, нийтийн эргүүлийг зохион байгуулж, эргүүлийн чиглэлийг 760-аар нэмэгдүүлж ажилласнаар 2020 оны эхний 9 сарын байдлаар нийт гэмт хэрэг 29,7 хувиар, гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 26,2 хувиар тус тус буурч, хэргийн илрүүлэлт 13,8 хувиар, зөрчлийн илрүүлэлт 29,7 хувиар өссөн дүнтэй байна.




8

Нийслэлийн гудамж, зам талбайд 2017-2020 онд нийт 1111 камерыг шинээр сурилуулж Улсын төсвийн хөрөнгө оруулалт 354 сая төгрөг, Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт 53 сая төгрөг, Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт 3,184 сая төгрөг тус тус зарцуулсан. 2019 онд улсын төсвөөс 1 тэрбум 750 сая төгрөг төсөвлөгдөж Нийслэлийн Баянзүрх, Баянгол дүүргийн зарим хороодын гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг гудамж зам талбайг камержуулах ажил 2019, 2020 онд хийгдсэнээр 2020 оны эхний 9 сарын байдлаар нийт гэмт хэрэг 29,7 хувиар, гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 26,2 хувиар тус тус буурч, хэргийн илрүүлэлт 13,8 хувиар,

1
 2
 3
 4
 5
 6
 7
 8
 9
 10
 11
 12
 13
 14
 15
 16
 17
 18
 19
 20
 21
 22
 23
 24
 25
 26
 27
 28
 29
 30
 31
 32
 33
 34
 35
 36
 37
 38
 39
 40
 41
 42
 43
 44
 45
 46
 47
 48
 49
 50
 51
 52
 53
 54
 55
 56
 57
 58
 59
 60
 61
 62
 63
 64
 65
 66
 67
 68
 69
 70
 71
 72
 73
 74
 75
 76
 77
 78
 79
 80
 81
 82
 83
 84
 85
 86
 87
 88
 89
 90
 91
 92
 93
 94
 95
 96
 97
 98
 99
 100

зөрчлийн илрүүлэлт 29,7 хувиар өссөн дүнтэй байна.

9. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 126 дугаар тогтоолоор “Хөршийн хяналт” хөтөлбөр”, “Хөршийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг батлуулж хэрэгжүүлж байна.



Одоогийн байдлаар Нийслэл хотын хэмжээнд 395 бүлэг сайн дурын 2560 гишүүнтэйгээр гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр цагдаагийн байгууллагатай хамтран ажиллаж байна.

10. Би цагдаа” буюу “iPolice” цуврал подкастийн сувгийг 2020 онд шинээр нээж ub.police.gov.mn цахим хуудас болон “Нийслэлийн цагдаагийн удирдах газар” фейсбүүк олон нийтийн сүлжээ хуудсанд тусгай булан нээн ажиллуулж байна.

“iPolice” цуврал подкаст нэвтрүүлгээр иргэд, олон нийтэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль эрх зүйн талаар мэдээлэл өгөх, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг сурталчлахаар тус бүр 30-40 минутын хугацаатай нэвтрүүлгийг явуулж байна. Одоогийн байдлаар 12 удаагийн цуврал иргэд олон нийтэд хүргээд байна.







11. Цагдаагийн байгууллага, алба хаагчтай холбоотой мэдээлэл, гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг иргэд аж ахуйн нэгжээс цахим хэлбэрээр авах “Ухаалаг цагдаа” цахим өргөдөл, гомдлын нэгдсэн програмыг цагдаагийн байгууллагын нэгдсэн сантай холбож “Цагдаагийн байгууллагын цахим үйлчилгээ” буюу www.service.police.gov.mn цахим хуудсыг 2016 оноос ажиллагаанд оруулсан.

Ингэснээр иргэд цагдаагийн байгууллагад гомдол гаргасан, дуудлага өгсөн шийдвэрлэлтийг SMS хэлбэрээр мэдэгддэг болсон. Тухайлбал: “Тусгай дугаарын програм”-ын UB Police, 131102


дугаараас **78778** мессэж иргэдийн гар утсанд илгээгдсэнээс “Мобиком” ХХК-ийн дугаарт 35069 буюу 44.5%, “Юнител” ХХК-ийн дугаарт 28461 буюу 36.1%, “Скайтел” ХХК-ийн дугаарт 12642 буюу 16.4%, “Жи-Мобайл” ХХК-ийн дугаарт 2606 буюу 3.3% байна.


ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
SERVICE INFORMATION SYSTEM

НҮҮР ХУУДАС


 ГОМДОЛ МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ	 ГОМДОЛ МЭДЭЭЛЭЛ ШАЛГАХ
 ЭРЭН СУРВАЛЖЛАГДАЖ БУЙ ЭТГЭЭД	 ЯЛ ШИЙТГЭЛИЙН ТОДОРХОЙЛОГ АВСАН ЭСЭХ ЛАВЛАГАА

УХААЛАГ ЦАГДАА
ЦАХИМ ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН
НЭГДСЭН СИСТЕМ





ӨРГӨДӨЛ ӨГӨХ



ӨРГӨДӨЛ ШАЛГАХ

11. Олон улсын сайн туршлага, хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөв хүмүүжил, зөв төлөвшил, зөв хандлага олгох, өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах дадал хэвшил олгох зорилгоор



“Сэргийлэгч хүү, охин”-ы баг шинэ дүрийг бий болгож олон нийтийн арга хэмжээ, ерөнхий боловсролын сургуулиуд дээрх сургалт, нөлөөллийн арга хэмжээ, телевиз, олон нийтийн цахим сүлжээн дэх контент зэрэг олон төрлийн ажил, арга хэмжээнд ашиглаж байна. Тухайлбал “Дрем бокс”, “Боловсрол суваг” ТВ-ээр хүүхдийн аюулгүй байдлын зөвлөмж бүхий 70 цуврал “2D”

анимешн, Бонго, Мажухын шинэ найз Буянаагийн 8 ангит шинэ зохиол, цуврал сэрэмжлүүлэг контент бүтээж хүүхэд, багачуудад хүргэж, Монголын өсвөр үе, хүүхдүүдийн дунд өөрийн гэсэн шинэ дүр, имижтэй болсон байна.

12. Тэнэмэл, гуилга гуйдаг, орон гэргүй, сургууль завсардсан, гэр бүлийн хүчирхийлэл болон бусад төрлийн гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирч, холбогдож болзошгүй хүүхдийг илрүүлэх, бүртгэх, хүүхэд хамгаалын хариу үйлчилгээ үзүүлэх зорилготой “Хүүхдийн нэгдсэн бүртгэл” цахим санг Цагдаагийн байгууллагын Мэдээллийн сангийн -Судалгаа хяналт сан”-д шинээр үүсгэн ажиллуулж эхлээд байна.

Энэ цахим сан үүссэн нь улсын хэмжээнд ашиглах боломжтой ба 2000 орчим хүүхдийг бүртгэж, тэдэнд чиглэсэн нэг бүрчилсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулж байгаа нь зорилтот бүлгийн хүүхдэд чиглэсэн чухал ажил болсон.

Судалгаа хяналт Батзориг Б.а/а

Субъектийн жагсаалт

Хариуцсан нэгж: Хэлтэс, тасаг, хэсэг: Алба хаагч: Мэдээлэл бичсэн:


Зураг	Бүртгэлийн дугаар	Огноо	Төлөв	Газар хэлтэс	Алба хаагч	Регистр	Эцэг эхийн нэр	Нэр	Дуудаг нэр / хоч	Ангиал
	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>	Хүүхдийн нэгдсэн бүрт
	5740073210000170	2021-03-30	Бүртгэгдээгүй	Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газрын 3-р хэлтэс	Маралмаа Б.д/а				Ч	Хүүхдийн нэгдсэн бүрт
	5740061210000442	2021-03-30	Бүртгэгдээгүй	Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн газрын 1-р хэлтэс	Ганзул Г.а/х				Баг	Хүүхдийн нэгдсэн бүрт
	5740073210000169	2021-03-30	Бүртгэгдээгүй	Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газрын 3-р хэлтэс	Маралмаа Б.д/а				Хүе	Хүүхдийн нэгдсэн бүрт

Хуудсанд харуулах хэмжээ: 20 Нийт: 643


13. Сургуулийн орчны аюулгүй байдлыг хангах олон улсын сайн туршлагыг нэвтрүүлж Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2015 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 177 дугаар тогтоолоор “Сургуулийн эргүүл” ажиллах журмын батлуулж, сургуулийн орчинд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургууль болон сурагчдын эцэг эхчүүдийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор дундажаар 1600 орчим эцэг, эхчүүд “Сургуулийн эргүүл” буюу “School police” эргүүлийг ажиллуулж хэвшүүлсэн байна. Энэ төсөл хэрэгжсэнээр сургуулийн орчинд хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчил 85 хувиар буурсан.



14. Хүүхдүүдэд чиглэсэн олон нийтийн нөлөөллийн ажил, арга хэмжээнд ашиглах, хүүхдийн аюулгүй байдлыг хангах сэдэвтэй “Гэрэлт ирээдүй” шинэ дуу, клипийг зохиолгож 2021 оны 03 дугаар сараас эхлэн ашиглаж эхлээд байна. Энэхүү дүү, клипийн хоолой, дүрсжүүлэлтийг Сэргийлэгч Хүү, Сэргийлэгч Охин хийсэн нь хүүхдүүдийн дунд хандалт ихтэй байна.



15. Зан төлөвийн эмгэг, стресс, ядралт, идэвх, авьяас сонирхол, мэргэжлийн чиг хандлагын багц **оношилгооны компьютер программ аргачлалыг үйл ажиллагаанд**



нэвтрүүлж,




19 нэгжийн 280 алба хаагч, 5 хүүхдийг оношилж, тодорхойлж, зөвлөмж өгсөн. Мөн түүнчлэн хүний нөөцийг сонгон шалгаруулах, албан тушаал дэвших болон сахилга ёс зүйн зөрчлийн сэтгэл зүйн шалтгаант асуудлыг богино хугацаанд илрүүлэх, цаашид зөвлөгөө, заслын угтвар

нөхцөлийг бүрдүүлэхэд ашиглаж байна.

16. Аудио контент /подкаст/ онлайн харилцан ярианы орчин бий болгох ажлыг судалж, хэрэгжүүлэв.

Алба хаагчдын сэтгэл зүйн боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор төв, орон нутгийн цагдаа дотоодын цэргийн анги, байгууллагын сэтгэл зүйчдийн оролцоотойгоор “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагч нарт сэтгэл зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх цахим хэлбэрийн бичлэг, нийт 12 подкастыг төв орон нутгийн сэтгэл зүйчдийг зочноор оролцуулж, аудио контентийг бэлтгэн цагдаагийн байгууллагын дотоод сүлжээ info.police.gov хаяг болон нийслэлийн цагдаагийн удирдах газрын хаалттай группэд байршуулж, алба хаагчдад таниулж ажилласан байна.



Алба

хаагчдыг дээрх пэйж хуудсанд байршуулсан подкастыг тогтмол сонсож, ухамсар, төлөвшлийг хэвшүүлэх чиглэлээр ажиллаж байна.

17. Жил бүрийн 6 дугаар сарын 10-ны дотор “Ахмадын нэг өдөр” өдөрлөгийг зохион байгуулж хэвшсэн.

Ахмад ажилтан, алдар цуутай буурлуудаа дурсан хүндэтгэх, тэдний ариун нандин, дайчин нөхөрлөлийг сэргээн бэхжүүлж, уулзуулах, амралт чөлөө цагийг нь ая тухтай өнгөрүүлж, сэтгэлийг нь сэргээж, ахмадын хорооныхоо үйл ажиллагааг сурталчилах зорилгоор 2015 оноос Нийслэлийн цагдаагийн удирдах газар Ахмадын хороотой хамтран жил бүр дараалан зохион байгуулсан.




18. “Бид мартаггүй”, Чөлөөнд гарсан ахмадуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг жил бүр 1 удаа зохион байгуулж, уламжлал болгосон.

Хүний эрхийг хамгаалах өдөртэй холбогдуулан цагдаагийн алба хаагчийн эрхийг хамгаалах зорилгоор Төр, ард түмнийхээ өмнө өргөсөн тангарагтаа үнэнчээр зүтгэн албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа эрсэдсэн журмын нөхдөө эргэн дурсах “БИД МАРТАХГҮЙ” арга хэмжээг 2009 оноос одоог хүртэл зохион байгуулж байна.




19. Цагдаагийн байгууллагын түүхэн замнал, үйл ажиллагааг сурталчлах, удам дамжин цагдаагийн албанд зүтгэж яваа ахмад үе, алба хаагчдаа олон нийтэд таниулах зорилгоор “Удам дамжсан цагдаа бидний бахархал” өдөрлөгийг 2016 онд зохион байгуулсан.



ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ ХЭЛТЭС
**ГЭРЧ, ХОХИРОГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ
 ХАНГАХ ЦАХИМ ХЯНАЛТЫН СИСТЕМ 2018 ОН**

Монгол улсад интернэт хэрэглэгчдийн тоо 2012 онд 654 мянга байсан бол 2019 онд 3.1 саяд хүрч 4.5 дахин нэмэгдсэн. Монгол улс өнөөдөр фейсбүүк хэрэглээгээрээ Азидаа нэгд, дэлхийд 10 дугаарт орж, иргэдийн цахим хэрэглээ өссөнтэй холбогдуулан Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн албан ёсны фейсбүүк цахим хаягийн мессенжерийг Чатбот /автомат хариулагч/-той болгож, гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааны талаар мэдээллийг иргэдэд түргэн шуурхай хүргэх, хэлтсийн үйл ажиллагааг сурталчлан таниулах ажлыг хэрэгжүүлж байна.

МОНГОЛ ЦАГДАА




Чатботыг 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс үйл ажиллагаандаа ашиглаж эхэлснээс 5 хоногийн хугацаанд 402 хүн бусадтай хуваалцаж /share/, 38 лайк авч, Чатботод 250 иргэн хандаж мэдээлэл авсан нь гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааг сурталчлах, иргэд өөрийн болон бусдын эрх, амь нас, эрүүл мэндийг хамгаалуулах талаарх мэдээллийг түргэн шуурхай авах боломжийг бүрдүүлсэн.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ТӨВ
**ГЭРЧ, ХОХИРОГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ
 ХАНГАХ ЦАХИМ ХЯНАЛТЫН СИСТЕМ 2018 ОН**

МОНГОЛ ЦАГДАА

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээний хүрээнд гэрч, хохирогч, заналхийлэгч этгээдийн хөдөлгөөн байршлыг тогтоох, хянах, аюулын дуудлагыг шуурхай хүлээн авах зорилгоор үүрэн холбооны операторын сүлжээнд ажиллах /GPS/ байршил тогтоогч төхөөрөмж, хяналтын камер, техник хэрэгслээр хяналт тавих Цахим хяналтын системийг бий болгож, хяналтын төвийг 2018 онд байгуулсан.



ХҮРСЭН ҮР ДҮН:

Гэрч, хохирогчийг хамгаалах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээний хүрээнд техник хэрэгсэл ашиглан Цахим хяналтын төв, хөдөлгөөнт төхөөрөмжөөс хяналт тавьснаар алба хаагчдын ажлын ачааллыг бууруулж, хамгаалалтын арга хэмжээний явцад учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аюулын дуудлагыг шуурхай хүлээн авах боломж бүрдсэн.

2018- 2020 онд нэг бүрийн тусгай хэрэгсэл, тусгай техник хэрэгслээр хангах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг 15 удаа хэрэгжүүлж, 31 удаагийн биечилсэн хамгаалалтын, 16 удаагийн аюулгүй газарт түр байрлуулах хамгаалалтын арга хэмжээнд техник хэрэгслийг ашиглан цахимаар хяналт тавьж, алба хаагчдын ажлын ачааллыг бууруулан хамгаалалтын арга хэмжээнүүдэд учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлсэн.

СҮЛД ЧУУЛГА
“ҮРГЭЛЖ ТАНТАЙ ХАМТДАА” ДУУ

“Үргэлж тантай хамтдаа” цогц өдөрлөг болон нийт зохион байгуулж байгаа соён гэгээрүүлэх урдаг соёлын ажлын үр дүн нь Монголын цагдаагийн байгууллагын бие бүрэлдэхүүнний дунд зохион байгуулах ажлын агуулга, хэлбэрийг баяжуулж, сахилга, ёс зүйг төлөвшүүлэх, сахилгын зөрчлийг таслан зогсоох, бууруулахад эерэг нөлөө үзүүлсэн.

УСДМ АСМ



ЦЕГ-ЫН ХМТ-ИЙН ЦАГДААГИЙН ХУРАНДАА Б.БААТАРХҮҮ


Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн орчинд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийг бууруулахад сургууль болон сурагчдын эцэг эхчүүдийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2015 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 177 дугаар тогтоолоор “Сургуулийн эргүүл” ажиллах журмын батлуулж, нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиудад өдөрт дундажаар 8 эцэг, эхчүүдийг цалинтай чөлөө олгуулж сургуулийн орчимд эргүүлээр ажиллаж байна. Энэхүү журам ажилласнаар нийслэлд 2020 оны 9 дүгээр сарын байдлаар өдөрт дундажаар 1600 орчим эцэг эхчүүд “School police” эргүүлээр ажиллаж хэвшсэн байна. Энэ төсөл хэрэгжсэнээр сургуулийн орчинд хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчил 85 хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байна.



БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ ДЭХ ЦАГДААГИЙН ГАЗРЫН НЭГДҮГЭЭР ХЭЛТЭС
ШИНЭ САНАЛ САНААЧИЛГА, ТЭРГҮҮН ТУРШЛАГА БОЛСОН
АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

УСДМБААБМ

Согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцлийг арилгах, хор уршигийг таниулах, урьдчилан сэргийлэх зорилгоор тус хэлтсийн Эрүүлжүүлэх саатуулах байранд 5 ширхэг дэлгэцийг Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд санал хүргүүлэн шийдвэрлүүлж байрлуулсан. Тус дэлгэцээр гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх утга бүхий видео бичлэгийг 4800 иргэнд үзүүлж, Эрүүлжүүлэх саатуулах байрны алба хаагчид архины хор уршигийг ухуулан сурталчлах ажлыг өглөө бүр зохион байгуулан ажиллаж байна.



ХҮРСЭН ҮР ДҮН:

Дээрх сургалтыг тогтмол зохион байгуулан ажилласанаар 2021 оны нэгдүгээр улиралд нийт дуудлага мэдээлэл 1914 нэгжээр буюу 17,4 хувиар, гэр бүлийн хүчирхийллийн дуудлага мэдээлэл 64 нэгжээр буюу 4,9 хувиар, согтуугийн дуудлага мэдээлэл 215 нэгжээр буюу 5,8 хувиар, эрүүлжүүлэгдсэн иргэдийн тоо 1277 нэгжээр буюу 37,8 хувиар өмнөх оны мөн үеэс тус тус буурсан эерэг үзүүлэлттэй байгааг илтгэн танилцуулъя.

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ ДЭХ ЦАГДААГИЙН ГАЗАР
 ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ, ЭРЭН СУРВАЛЖЛАХ ЧИГЛЭЛЭЭР
 САНААЧИЛСАН, ТЭРГҮҮН ТҮРШЛАГА БОЛСОН АЖИЛ, А РГА ХЭМЖЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ ДЭХ ЦАГДААГИЙН ГАЗАР

Бидний амьдарч буй өнөөгийн нийгэмд гар утас, таблет, компьютер, интернет, сүлжээ гэх мэт цахим төхөөрөмжүүдээс бидний өдөр тутмын амьдралын хэрэгцээ, шаардлага улам бүр хамааралтай болсоор байгаа энэ үед тус цагдаагийн газрын гуравдугаар хэлтсийн эрүүгийн ахлах мөрдөгч, цагдаагийн ахмад М.Амармэнд “Нийтийн байрны нэгдсэн сан” www.ibair.mn сайтыг зохион бүтээж, гэмт хэрэгтэй тэмцэх, эрэн сурвалжлах чиглэлээр үйл ажиллагаандаа ашиглаж байна. Уг сайтыг ашигласнаар нийтийн байрны эзэмшигч нар болон алба хаагч нарын ажлыг хөнгөвчлөхөөс гадна цагдаагийн байгууллагаас нийтийн байруудыг бүрэн хяналтанд авах боломжтой юм.

“Нийтийн байрны нэгдсэн сан” www.ibair.mn программ хангамж нь Оюуны өмчийн газрын даргийн 2020 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А/68 дугаар тушаалаар 11540 дугаартай зохиогчийн эрхийн гэрчилгээ авсан.

Уг сайтыг зохион бүтээхэд нийтийн байрны эзэмшигч нарын бүртгэл, судалгаа, хүндрэл бэрхшээлийн талаар судлаж, сайтын шаардлагатай цэсийг нэмэх, хасах чиглэлээр тогтмол хөгжүүлэлт хийгдэж 1 жил 6 сарын хугацаа зарцуулсан.



ХҮРСЭН ҮР ДҮН:

“Нийтийн байрны нэгдсэн сан” www.ibair.mn сайтыг ашигласнаар Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн газрын хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 157 нийтийн байранд түрээсээр оршин сууж байгаа 1371 иргэнийг бүртгэж тухайн иргэдээс цагдаагийн байгууллагын АСАП санд эрэн сурвалжлагдаж байсан 21 этгээдийг олж тогтоон, 98 иргэнийг судалгаанд явч, шилжилт хөдөлгөөнд нь хяналт тавин ажиллаж байна.

Цаашид Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа Нийтийн байруудыг бүртгэж тухайн нийтийн байранд орогнож байгаа этгээдүүдийг олж тогтоохоор ажиллаж байна.

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ ДЭХ ЦАГДААГИЙН ГАЗРЫН ХОЁРДУГААР ХЭЛТЭС

УСДМ ААЦБМ



Алслагдсан хороодын иргэдэд цагдаагийн байгууллагын ажил үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдээ мэдээлэл хүргэх зорилгоор 2016 онд Авеко маркын автомашиныг лед дэлгэж, хяналтын камер, боловсон ОО, ширээ, сандал, интернет орчин бүхий иж бүрэн тоноглож үйл ажиллагаандаа ашиглаж байна



ХУД ДЭХ ЦАГДААГИЙН НЭГДҮГЭЭР ХЭЛТЭС
ХАН-УУЛ ДҮҮРЭГ ДЭХ ЦАГДААГИЙН НЭГДҮГЭЭР ХЭЛТЭС
 **ШИНЭ САНАА САНААЧИЛГА**

МОНГОЛ ЦАГДАА

Тус цагдаагийн хэлтсээс 2020 онд Дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, ГХУСАЗСЗ-тэй хамтран бие даасан ЭЦТ, МБТ, ХБТ, НХЖХТ, ШУТ, УС-ахлах байцаагч нар зэрэг 5 тасгийн дунд хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд ихээр үйлдэгддэг Иргэдийн өмчийн хулгай, Орон байр, Халаасны хулгай, Залиллан мэхлэх гэмт хэрэг, БЭМХБЭГХ, Гэр бүлийн хүчирхийлэл, Хүүхдийн гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх чиглэлээр “ШТОРК” болзолт уралдаан 30 хоногийн хугацаатай зарлаж нийт 6 төрлийн шинэ шторктой болж тодорхой төрлийн гэмт хэргүүдээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зурагт болон цахим сайтуудад байршуулан иргэд олон нийтэд мэдээ, мэдээлэл хүргэж сурталчилан ажилласан.



Хүрсэн үр дүн:

Тус цагдаагийн хэлтэст 2020 оны байдлаар 868 гэмт хэрэг бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 226 хэрэг буюу 20,7 хувиар буурсан.

Гэмт хэргийн илрүүлэлт 43 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

ХАН-УУЛ ДҮҮРЭГ ДЭХ ЦАГДААГИЙН НЭГДҮГЭЭР ХЭЛТЭС ШИНЭ САНАА САНААЧИЛГА

МОНГОЛ ЦАГДАА

Монгол Улсад хууль зүйн алба үүсэн байгуулагдсаны 110, Цагдаагийн байгууллага үүсэн байгууллагадсаны 100 жилийн ой угтан мөн “Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын соёлыг төлөвшүүлэх хөтөлбөр”, “Өнгө нэмье-2020” нөлөөллийн аяны хүрээнд хүрээнд Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албанаас зохион байгуулсан “Нэг сэтгэл, нэг соёл” аяны хүрээнд Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсийн 2020 оны сургалт, соён гэгээрүүлэх ажлын календарчилсан төлөвлөгөөг тасаг, хэсгийн алба хаагчдын зургийн цомог, уриа бүхий он цагийн хуанли болгон хэвлүүлж өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэглэж байна.

Хүрсэн үр дүн: Зохион байгуулсан арга хэмжээ хэлтсийн оны сургалт, соён гэгээрүүлэх ажлын календарчилсан төлөвлөгөөг гаргаснаар хэлтсийн нийт алба хаагчид ажлаа долоо хоног, сараар төлөвлөн арга хэмжээнүүдэд хоцролт, таслалтгүй хамрагдсан байна.

БАГАНУУР ДҮҮРЭГ ДЭХ ЦАГДААГИЙН ХЭЛТЭС

“НИСДЭГ ДРОН” АРГА ХЭМЖЭЭГ 2019 ОНЫ 01 САРААС ЭХЛЭН ХЭРЭГЖҮҮЛЭН АЖИЛЛАЖ БАЙНА.

Урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд цагдаагийн хэлтсийн алба хаагчдыг тавтын системд оруулж алба хаагч бүр өөрийн хариуцаж авсан иргэдтэй 14 хоногт 3 удаа тохиромжит цагт уулзалтыг зохион байгуулж, уулзалтаар иргэний амьдарч буй газар, эрхэлж байгаа ажил, санхүүгийн эх үүсвэр, олны дунд биеэ хэрхэн авч яваа байдал, хяналт тавьж буй иргэний сэтгэлийг хэрхэн эерэгээр татах талаар урьдчилан бэлдсэн ярианы сэдэв, түүний ар гэрт цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг зөв таниулж ойлгуулах зэргээр нөлөөллийн арга хэмжээ авч, хууль сурталчилж ухуулах ажлыг зохион байгуулж ажиллалаа.

“Нэг бүрчилсэн хяналт” урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд цагдаагийн хэлтсийн алба хаагчдыг тавтын системд оруулж алба хаагч бүр өөрийн хариуцаж авсан иргэдтэй 14 хоногт 3 удаа тохиромжит цагт уулзалтыг зохион байгуулж, уулзалтаар иргэний амьдарч буй газар, эрхэлж байгаа ажил, санхүүгийн эх үүсвэр, олны дунд биеэ хэрхэн авч яваа байдал, хяналт тавьж буй иргэний сэтгэлийг хэрхэн эерэгээр татах талаар урьдчилан бэлдсэн ярианы сэдэв, түүний ар гэрт цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг зөв таниулж ойлгуулах зэргээр нөлөөллийн арга хэмжээ авч, хууль сурталчилж ухуулах ажлыг зохион байгуулж ажиллалаа.

“Нэг бүрчилсэн хяналт”-д гэмт хэрэг, зөрчилд холбогдож байсан, холбогдох эрсдэл өндөр, архины хамааралтай, бүлэг бөөгнөрөл үүсгэдэг иргэдийн судалгааг гаргаж эрсдэл өндөр 120 иргэнийг хяналтад авч урьдчилан сэргийлэх нөлөөллийн нэг бүрчилсэн хяналтын ажлыг түлхүү зохион байгуулан ажиллахад гэмт хэрэг, зөрчлийн гаралт тодорхой түвшинд буурч илрүүлэлт өссөн эерэг үр дүнд хүрсэн. “Нэг бүрчилсэн хяналт” урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээг 3 дах жилдээ үргэлжлүүлэн зохион байгуулж байна.



“НЭГ БҮРЧИЛСЭН ХЯНАЛТЫН СХЕМ” гайлбар

A	100-ын дарга Дэд бөгөөд эрүүгийн тасгийн дарга
A	25-ын дарга цагдаагийн хэлтсийн тасгийн дарга нар
A	5-ын дарга ахлах мэргэжилтэн, байцаагч нар

■	МӨРДӨГЧ
■	ОФИЦЕР
■	АХЛАГЧ



ХҮРСЭН ҮР ДҮН:

“Нэг бүрчилсэн хяналт” урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээг үр дүнтэй тогтмол зохион байгуулсанаар 2019 онд иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас 1889 гомдол мэдээлэл хүлээн авсан нь өмнөх оны мөн үеэс 579 нэгжээр буюу 23.4 хувиар буурчээ. Үүнээс: Гэмт хэргийн талаарх 397 гомдол мэдээллийг хүлээн авч шийдвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 85 нэгж буюу 17.6 хувиар, зөрчлийн талаарх 1492 гомдол мэдээлэл шийдвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 494 нэгжээр буюу 24.8 хувиар тус тус буурсан байна.

Тодорхой төрлийн гэмт хэргээс дурдвал: Согтуугаар үйлдэгдсэн хэрэг 59 бүртгэгдэж өнгөрсөн оны мөн үеэс 39 нэгжээр буюу 39.7 хувиар, хүүхэд оролцсон хэрэг 11 бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 2 нэгжээр буюу 11.5 хувиар, бүлэглэн гүйцэтгэсэн хэрэг 13 бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 2 нэгжээр буюу 13.3 хувиар, эмэгтэй хүн оролцсон хэрэг 19 бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 4 нэгжээр буюу 17.3 хувиар тус тус буурсан эерэг тоон үзүүлэлттэй байна.

2020 онд иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас 1703 гомдол мэдээлэл хүлээн авсан нь өмнөх оны мөн үеэс 186 нэгжээр буюу 9.8 хувиар буурсан байна. Үүнээс: Гэмт хэргийн талаарх 352 гомдол мэдээллийг хүлээн авч шийдвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 45 нэгж буюу 11.3 хувиар, зөрчлийн талаарх 1351 гомдол мэдээлэл шийдвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 141 нэгж буюу 9.4 хувиар тус тус буурчээ.

Тодорхой төрлийн гэмт хэргээс дурдвал: Бусдын эд хөрөнгө хулгайлах гэмт хэрэг 23 нэгжээр буюу 32.3 хувь, мал хулгайлах гэмт хэрэг 6 нэгжээр буюу 55 хувь, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг 5 нэгжээр буюу 56 хувиар тус тус буурсан эерэг үзүүлэлттэй байна.

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ХЭЛТЭС. ШИНЭ САНАЛ САНААЧИЛГА, ТЭРГҮҮН ТУРШЛАГА БОЛСОН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

ЦАГДАА
 АЖИЛ
 АРГА
 ХЭМЖЭЭНИЙ
 МЭДЭЭЛЭЛ

Зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх, хорио цээрийн үед хяналт тавих хөдөлгөөнт постоор ашиглагдах “Газ” маркын автобусны тохижилт, засвар үйлчилгээний ажилд шаардагдах 8.0 сая төгрөгийг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зохицуулах салбар зөвлөлд санал хүргүүлэн шийдвэрлүүлж алба хаагчдын ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

Цагдаагийн хэлтсээс Сүмбэр сумын Засаг даргын тамгын газартай хамтран иргэдийн дундах архины хэрэглээг багасгах, архинд донтсон иргэдийг тодорхой хувиар бууруулах зорилгоор “Архидалтгүй Сүмбэр” арга хэмжээг зохион байгуулж, архинаас гарах чин хүсэл эрмэлзэлтэй 11 иргэнийг Дорнод аймгийн Хэрлэн сум дахь “Ухаарал” сэтгэц, наркологийн эмнэлэгт эрүүл мэндийн сайн дурын үйлчилгээнд хамруулав.



Хүрсэн үр дүн:

Зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх хөдөлгөөнд пост ажиллуулснаар алба хаагчдын ажиллах орчин нөхцөл сайжирч, энэ оны 01 дүгээр улиралын байдлаар зам тээврийн осол хэрэг урьд оны мөн үетэй харьцуулахад 33.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Сүмбэр сумын хэмжээнд иргэд олон нийтийн аюулгүй, амар тайван орчинд амьдрах нөхцөл бололцоог ханган, байнга архи дан согтуурдаг иргэдийн тоо буурч, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 6 бүртгэгдсэн урьд оны мөн үетэй харьцуулахад ижил түвшинд байна.

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН ШИНЭ САНАЛ САНААЧИЛГА, ТЭРГҮҮН ТУРШЛАГА БОЛСОН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ



Цагдаагийн, дотоодын цэргийн анги байгууллагаас 2019 онд дэвшүүлсэн зорилтын хүрээнд сум орон нутагт ажиллаж байгаа хэв журмын цагдаа нарын сахилга хариуцлага, мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, сургаж дадлагажуулах, цэрэгжилт жагсаалч байдлыг сайжруулах, сум орон нутагт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, шинээр батлагдан гарсан хууль тогтоомж, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг иргэдэд сурталчлах, сум орон нутгийн эрүү хэв журмын нөхцөл байдлын тогтоох зорилгоор Цагдаагийн газрын даргын 2019 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар “Сумдын цагдаа нарыг солилцоогоор ажиллуулах арга хэмжээг 2019 оны 01 дүгээр сарын 10-наас 31-ны өдөр хүртэл 21 хоногийн хугацаанд зохион байгууллаа.



Сумдын 15 цагдаа аймгийн төвд ажиллах хугацаандаа нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр 67 удаа 404 цагийн эргүүлийн, 50 удаа 1224 цагийн харуул, жижүүрийн үүрэг гүйцэтгэж, 29 зөрчил илрүүлэн 29 хүнийг 905.000 төгрөгөөр торгож ажилласан байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Эрдэнэбулган сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдааны 2020 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор Эрдэнэбулган сумын хэмжээнд “Иргэний урамшилтай” эргүүлийг ажиллуулж эхэлсэн. Тус цагдаагийн газар нь сайн дурын 21 иргэнтэй гэрээ байгуулан “Иргэний урамшилтай” эргүүл ажиллуулах төлөвлөгөөний дагуу 7 хоног бүрийн 2, 5 дахь өдрийн 14:00-18:00 цагийн хооронд тогтмол ажиллуулж байна. Иргэний урамшилтай эргүүлийн өмсөх хантааз, таних тэмдэг, урамшуулал зэргийг Эрдэнэбулган сумын ГХУСАЗСЗ-ийн санхүүжилтээр улирал бүр нэг хүнд 80000 төгрөг тооцон олгож байна

ХОВД АЙМАГ ДАХЬ ЦЭРГИЙН ГАВЬЯНЫ ОДОНТ ЦАГДААГИЙН ГАЗАР

ЦЭРГИЙН ГАВЬЯНЫ ОДОНТ ЦАГДААГИЙН ГАЗАР

Ховд аймаг дахь Цагдаагийн газар нь аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран согтуугаар үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, хор уршгийг таниулах, урьдчилан сэргийлэх зорилгоор “No alcohol” аяныг 2019 оны 06 дугаар сард төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, игэдийн дэмжлэгтэйгээр зохион байгуулсан. Аяны хүрээнд Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, “Тунгалаг буянт” төрийн бус байгууллагатай хамтран Ховд аймгийн Жаргалант, Алтай, Булган, Манхан, Зэрэг, Дуут, Дарви, Ховд сумын архины архаг хамааралтай 30 хүнд “Архинаас татгалзъя” сургалт, нөлөөллийн арга хэмжээг 2 өдрийн хугацаатай вакумжуулсан хэлбэрээр зохион байгуулж, оролцогчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор газрын алба хаагчид хуваарийн дагуу байрлан үүрэг гүйцэтгэж, холбогдох мэргэжлийн байгууллагуудаар сэтгэл засал, эрүүл мэнд, нийгмийн ажил, хууль зүйн зөвлөгөө зэргийг үзүүлсэн.



ХҮРСЭН ҮР ДҮН:

Аян, вакумжуулсан сургалтын үр дүнд 12 иргэн архины хамаарлаас бүрэн ангижирч, ажлын байранд зуучиллаа.

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРААС
ОНЦЛОГ АЖЛЫН ТАНИЛЦУУЛГА**

Тус Цагдаагийн газраас аймгийн төвийн алба хаагчдыг 6 багт хуваарилан, нэг алба хаагчдад 30-50 өрх ноогдох хэлбэрээр хариуцуулан “Тэгш хэм”-ийн систем гэсэн нэршил бүхий ажлыг 2004 оноос амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна.

Нэг багийн тэгш хэмд тасаг бүрээс тэгш тоотойгоор алба хаагчдыг оролцуулан хуваарийг гаргаж, оны эхэнд баталгаажуулан тухайн багт үйлдэгдсэн ноцтой хэргийн талаар мэдээ, мэдээлэл цуглуулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ, аяны хүрээнд айл өрхөөс судалгаа авах, эрэн сурвалжлалт, иргэдээс санал хүсэлтийг нь авах зэрэг ажлуудыг тухай бүр нь төлөвлөгөөтэй зохион байгуулан ажилладаг.

“Тэгш хэм”-ийн системээр ажиллуулахын ач холбогдол нь алба хаагчдыг багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх, нөөц хүчийг тодорхой ажилд оновчтой төвлөрүүлэн ажилласнаар тухайн ажлыг үр дүнтэй зохион байгуулах явдал юм.



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН ЛОГО, ДАЛБААНЫ ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

Улаанхурээ



Дорноговь аймаг дахь цагдаагийн газрын бэлгэ тэмдгийн загварыг гадна талаар нь улаан өнгөөр хөвөөлсөн хүрээ бүхий ромбо хэлбэрийн шар дэвсгэр дээр дөрвөн зүгрүү харуулсан эрдэнийн очир дүрсийг байршуулж, төвд нь хоёр жигүүрээ тэгш хэмтэйгээр дэлгэн баруун далавчныхаа чигт соргог нүдээр сүрлэг харж, урт махир хумстай сарвуу бүхий хоёр хөлөөрөө нумны хөвчийг эвшээлгэн жийж суусан, эрэмгий зориг, шударга ёс, цог хийморь, шаламгай хурдны шинж бүрдмэл цагаан шонхор шувууг дүрсэлж, түүний толгойны чанх дээр эвийн таван сумны зэвийг эгц дээшээ чиглүүлж зэрэгцүүлэн залсан байна.

Дугуй хөх дэвсгэрийн гадна талын цагаан хүрээний баруун зүүн хэсэгт уг зурвасны дөрөвний гуравтай тэнцэх зайнд “Монголын цагдаа” гэсэн үгийг монгол бичгээр, доод хэсэгт “police” гэсэн үгийг латин үсгээр тэмдэгний дэвсгэрийн өнгөтэй ижил тунгалаг хөх өнгөөр бичсэн, шонхор шувууны нүд, хушуу, хумсыг алтлаг өнгөөр ялган дүрсэлсэн.

Цагаан шонхорын доод талд Дорноговь гэж аймгийн нэрийг бичсэн.

- УЛААН ХҮРЭЭ: мандан бадарч, дүрэлзэн асах галыг бэлгэдсэн,
- ШАР ДЭВСГЭР: нарыг зүйрлэн үржин дэлгэрэх, цог жавхлан, мандан бадрахыг бэлгэдсэн.
- ЭРДЭНИЙН 4 ОЧИР: дөрвөн зүг, бат бөхийн бэлгэдэл, хэмхэрдэггүй, хагарч бутарч үл болох чанар лугаа барилдуулан хоосон чанарын бэлгэдэлтэй
- ШОНХОР ШУВУУ: Эзэн Чингис хаан Шонхор шувууг хурд хүч, зориг, авхаалж самбаа, эрч хүчний бэлгэдэл гэж үзэж ирсэн бөгөөд Монголчуудын эрхэмлэн дээдлэн ирсэн түүхэн уламжлалыг хадгалах, цагдаагийн байгууллага Шонхор шувуу мэт байхыг бэлэгдсэн. Бэлэгдлийн Шонхор шувууг далавччаа дэлгэсэн дүүрэн татсан нум мэт дүрсэлсэн нь мөн хурд хүчнийг бэлгэдсэн.
- СУМ: Дүүрэн татсан нум хэлбэртэй Шонхор шувууны дээд хэсэгт байрлах таван сум нь цагдаагийн ажилтны таван мэдэрхүй хурц байх мөн Алунгоо эхийн домогт өгүүлсэн эвийн бэлгэдлийг давхар агуулсан.
- СУУРЬ ЦЭНХЭР ӨНГӨ: Үргэлж өндөр дээд хөх тэнгэр мэт байрыг бэлгэдсэн.
- БИЧЭЭС: Дорноговь гэж аймгийн нэрийг бичсэн.

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗАР



1924 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар Хантайшир-Уулын аймгийг Улиастайд төвлөрүүлэн хар тамхи, мансууруулах бодис хэрэглэхээс хамгаалан тэмцэх, олон нийтийн амгалан тайван байдлыг сахиулах зорилгоор Улиастай хотод бага дарга нэг, цагдаа дөрөвийг томилон ажиллуулахыг Цэргийн яаманд даалгаснаар Завхан аймаг дахь цагдаагийн газрын анхны суурь тавигдсан билээ.

Цагдаагийн байгууллагын хөгжил дэвшил, өөрчлөлт шинэчлэлтийн дагуу бүтэц зохион байгуулалт, чиг үүрэг өргөжин хөгжиж ажилласаар эдүгээ 97 дахь жилийн түүхээ бичин хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

Түүхэн он жилүүдэд тус байгууллага нь идэвх санаачлилга, ололт амжилтаар дүүрэн ажиллаж бидний ахмад үе 1978, 1980, 1981 онуудад дараалан Улсын Цагдан Сэргийлэх Ерөнхий газрын тэргүүний байгууллага, хамт олноор шалгарч үүрд хадгалагдах “Улаан туг”-аар, Улсын Цагдан сэргийлэх байгууллагын 60 жилийн ойгоор Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1981 оны 07 дугаар сарын 14-ний өдрийн 243 дугаар зарлигаар төрийн дээд шагнал “Алтан гадас” одонгоор шагнагдаж, ахмад үеийн алдар гавъяа түүхэнд тодоор тэмдэглэгдэн үлдсэн нь алба хаагч бүрийн эрхэмлэн хүндлэх бахархал билээ.



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗАР

Өмнөговь аймаг дахь цагдаагийн газар

Тус цагдаагийн газрын Мөрдөн байцаах тасааг нь ахмад, дунд, залуу 3 үеийн уулзалт зохион байгуулж, мэргэшүүлэх, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх заавар зөвлөгөө өгөх зорилгоор “Ганцаарчилсан уулзалт”-ыг зохион байгуулав




Хүрсэн үр дүн:

Мөрдөгч нар албандаа хандах хандлага сайжирч, өрөө сейфны эмх цэгц, аюулгүй байдал нууцлал, хангагдаж хэрэг шийдвэрлэх ажиллагаанд ахиц гарсан.

УВС АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗАР ШИНЭ САНАЛ САНААЧИЛГА, ТЭРГҮҮН ТУРШЛАГА БОЛСОН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ



Цагдаагийн хошууч Ц.Жамбалдорж 2019 онд Эрүүгийн цагдаагийн тасгийн алба хаагчид хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж эхэлснээр тэдний гар дээр олон тооны эзэнгүй хэргүүд төвлөрч хугацаа алдах зөрчил нийтлэг байдлаар гарч прокурорын шаардлага авах болсон. Дээрх нөхцөл байдалд дүгнэлт хийж хэрэг бүртгэлтийн хэргийн тоо, хөдөлгөөн, хугацаанд хяналт тавих, хугацаатай албан бичгийн хугацаа хянах, мөн сэжигтэй этгээдүүдийг хянах гэсэн үндсэн 3 үүрэгтэй сүлжээний орчинд ажиллах боломжтой “Хяналт 1.0” программыг санаачлан зохион бүтээж үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн. Энэхүү програм нь хэрэг бүртгэлтийн хэрэг болон хугацаатай албан бичгийн хугацаа дуусахаас 2 хоног болон дуусах өдөр нь автоматаар идэвхжин хэрэглэгчид дохио өгч мэдээллэдэг онцлогтой. Мөн сэжигтэй этгээдүүд, тэдний хань харилцаа, үйл хөдлөлийн талаар авагдсан мэдээллийг нэгтгэх, хянах зориулалттай.



ЛАХҮРСЭН ҮР ДҮН:




Уг программыг ашиглаж эхэлснээр хэрэг бүртгэлтийн хэрэг болон хугацаатай албан бичгийн хугацаа алдах явдал бүрэн таслан зогсоогдсон. Одоо уг программыг Хөвсгөл, Архангай, Сүхбаатар, Булган аймаг, Хан-Уул, Баянгол дүүргийн цагдаагийн газар, хэлтсийн Эрүүгийн цагдаагийн тасгууд үйл ажиллагаанд ашиглаж байна.

УВС АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗАР ШИНЭ САНАЛ САНААЧИЛГА, ТЭРГҮҮН ТУРШЛАГА БОЛСОН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

Увс аймаг дахь цагдаагийн газар

Адууны зүсийг аймаг бүрт өөр, өөрөөр нэрлэж, нутгийн онцлог бүхий тамга дарж хэрэглэдэг онцлогтой. Иймд малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэж буй эрүүгийн мөрдөгч, хэсгийн төлөөлөгч нарт зориулан “Увс аймгийн адууны зүс, тамга, нэршил” гэсэн гарын авлагыг бэлтгэсэн бөгөөд гарын авлагад адууны зүсийг Увс аймагт хэрхэн нэрлэдэг, хөрш зэргэлдээ ОХУ-ын Тува улсад хэрхэн нэрлэдэг болохыг адууны зүс бүхий фото зургийн хамт тайлбартайгаар тусгасан.

Мөн тус аймаг хэрэглэж байгаа адууны тамганы судалгааг сум тус бүрээр нь ангилж гарган ЭЦА-ны хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, хил залгаа Баян-Өлгий, Ховд, Завхан, Говь-Алтай аймаг дахь Цагдаагийн газруудад хүргүүлсэн



ЛАХҮРСЭН ҮР ДҮН:

Малын зүс, им тамгаар нь 5 хэрэг илрүүлж, ASAP санд 18 малын эрэн сурвалжлалтыг зогсоож, бусад зэргэлдээ аймаг Оросын холбооны улстай хамтран ажиллаж туршлага судалсны үр дүнд Мал хулгайлах гэмт хэргийн гаралт 50 хувь буурсан.

УВС АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗАР ШИНЭ САНАЛ САНААЧИЛГА, ТЭРГҮҮН ТУРШЛАГА БОЛСОН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ
УЛСЫН
ХУУЛЬ
САНАЛ
САНААЧИЛГА
ТӨВЛӨРСӨН
МЭДЭЭЛЛИЙН
САН

Увс аймгийн хэмжээнд Эрүүгийн хуулийн 24.6 дугаар зүйлд заасан “Хууль бусаар мод бэлтгэх” гэмт хэрэг өмнөх оноос 2 дахин өссөн тул мод бэлтгэх, тээвэрлэх эрхийн бичгийн хяналтыг сайжруулах, хууль бусаар мод бэлтгэх үйлдлийг таслан зогсоох зорилгоор “goojin.atwebpgages.com” нэртэй цахим программыг бүтээж үйл ажиллагаандаа нэвтрүүлж туршилтаар ажиллуулж байна.

ХҮРСЭН ҮР ДҮН:

Уг программыг үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэнээр зохих зөвшөөрлийн дагуу мод бэлтгэж, тээвэрлэж буй иргэдэд төрийн байгууллагаас хүндрэл учруулахгүй байх нөхцөл бүрдсэн мөн мод бэлтгэх эрхийн бичиг, гарал үүслийн бичгийн төвлөрсөн мэдээллийн сан бий болсноор байгаль орчны салбарын байгууллагуудын хамтын ажиллагаа сайжирсан. Хууль бусаар мод бэлтгэх, авилга албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил болсон.

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗАР ШИНЭ САНАЛ САНААЧИЛГА, ТЭРГҮҮН ТУРШЛАГА БОЛСОН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

У.С.Д.Т.А.А.Ц.Т.А.

Тус Цагдаагийн газарт бүртгэлтэй байдаг албаны Зил-131 маркийн тээврийн хэрэгслийг тусгай зориулалтаар тоноглох аймагын төвийн алслагдсан баг, шаардлагатай газруудад хүрч ажиллах зорилгоор 2020 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр “Билэгт Ууган” ХХК-тай 01/06 дугаартай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан засварын ажлыг эхлүүлж энэ оны 02 дугаар сарын 18-ны өдөр ажлыг дуусгаж шаардлагатай цэгүүдэд үүрэг гүйцэтгэхэд бэлэн болгож албаны бэлэн байдлыг хангуулаад байна.



ХҮРСЭН ҮР ДҮН:

Тус тээврийн хэрэгслийг ашиглаж эхэлснээс хойш хугацаанд малын хулгайн хяналтад 23 удаа 24 цагаар явуулын постоор ажиллуулах мөн Ковид-19 цар тахлын үед нийт 41 хоног тасралтгүй 24 цагаар хөдөлгөөнд байдлаар пост ажиллуулж алба хаагч нар байрлаж ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлж үр дүнд хүрсэн

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗАР ШИНЭ САНАЛ САНААЧЛАГА, ТЭРГҮҮН ТУРШЛАГА БОЛСОН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар

Монгол Улсын Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчөөс “Архигүй Монголын төлөө” уриалгыг хэрэгжүүлэх зорилгоор 2012 онд тус цагдаагийн газраас санаачлан “Архигүй хэнтийчүүд хөтөлбөр”-ийг батлуулан хэрэгжүүлж, 2014 оны 06 дугаар сарын 27, 28-ны өдрүүдэд Улаанбаатарын хотод “Архигүй Хэнтий-бодит үр дүн-туршлага” үндэсний чуулганыг зохион байгуулсан.



ХҮРСЭН ҮР ДҮН:

Хөтөлбөр хэрэгжсэн хугацаанд нийт 983 иргэн архины хамаарлаас гарч, 2012-2016 онуудад согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 44-88 нэгжээр буурсан, одоогоор тус хөтөлбөрийг “Архидалтгүй Хэтийн Хэнтий” нэртэйгээр хэрэгжүүлж байна.

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗАР

“1993-2000 ОН ХҮРТЭЛ ХУГАЦААНД ДУНДГОВЬ АЙМГИЙН ЦАГДААГИЙН ХЭЛТСИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ” ГЭЖ 20 ЗААЛТ БҮХИЙ ЧИГЛЭЛ ГАРГАЖ, ҮР ДҮНГ ТООЦОЖ АЖИЛЛАСАН.

Цагдаагийн газрын даргын 2021.04.05-ны өдрийн А/24 дүгээр тушаалаар Цагдаагийн байгууллагын 100 жилийн ойг угтаж Монголын “Менежментийн зөвлөхүүдийн холбоо” төрийн бус байгууллагатай гэрээ байгуулж цагдаагийн газрын үйл ажиллагаанд чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартын зөрүүгийн шинжилгээ хийх, шинжилгээний үр дүнд үндэслэн зөвлөн туслах үйлчилгээ авч, дотоод аудит хийж баталгаажуулалт хийх ажлын хэсгийг байгуулсан.

“Монголын Менежментийн зөвлөхүүдийн холбоо” төрийн бус байгууллагатай гэрээ байгуулж цагдаагийн байгууллагад анх удаа ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэх эхний алхам болох зөрүүгийн шинжилгээ хийж зөвлөн туслах эхний үйлчилгээг авч хэрэгжүүлж байна.



A document page with a red stamp, a signature, and several paragraphs of text in Mongolian. It appears to be a formal agreement or report related to the certification process.

A document page titled 'БАТЛАМЖ' (Certification) from the Mongolian Management System Association. It lists 7 points of compliance with ISO 9001:2015 standards. At the bottom, there is a red circular seal and the date '2021 ОН'.